



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 оны I улирал



Цахим хувилбар

Энэхүү тайланд тусгагдсан үр дүн, тайлбар, дүгнэлт нь Эдийн засаг, хөгжлийн яамны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

Уг тайланг арилжааны бус зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглаж болох бөгөөд ашигласан тохиолдолд “Макро эдийн засгийн танилцуулга”, Эдийн засаг, хөгжлийн яам хэмээн эх сурвалж хэсэгт тодотгоно уу.

Санал хүсэлт болон өөр бусад мэдээллийн талаар асууж тодруулах бол info@med.gov.mn цахим шуудан эсвэл дараах хаягаар хандана уу.

Эдийн засаг, хөгжлийн яам, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр, Улаанбаатар хот 15141, Монгол Улс



ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ РҮҮ

АГУУЛГА

Хураангуй дүгнэлт	5
Богино хугацааны төлөв	6
Бодлогын зорилт	7
I. Бодит сектор	8
1.1. Нийт нийлүүлэлт	10
1.2. Нийт эрэлт	13
1.3. Хөдөлмөр ба бизнес	16
1.4. Эдийн засгийн мөчлөг	18
II. Төсвийн сектор	21
2.1. Төсвийн бодлого	23
2.2. Засгийн газрын өрийн тогтвортой байдал	25
III. Мөнгөний сектор	27
3.1. Инфляц ба мөнгөний бодлого	29
3.2. Санхүүгийн салбар	31
IV. Гадаад сектор	35
4.1. Гадаад худалдаа	37
4.2. Төлбөрийн тэнцэл	42
4.3. Гадаад өр	44
V. Дэлхийн эдийн засаг	46
5.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал	48
5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага	50
VI. Эрсдэл	51
Хавсралт	53

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг I.1. Бодит ДНБ-ий өсөлт	11
Зураг I.2. Том малын зүй бус хорогдол	12
Зураг I.3. Том малын зүй бус хорогдлын 2024 оны төсөөлөл	12
Зураг I.4. Өсөлтийн бүтэц	15
Зураг I.5. Хөдөлмөрийн зах зээл	16
Зураг I.6. Бизнес регистр	17
Зураг I.7. Үйлдвэрлэлийн зөрүү	18
Зураг I.8. Үйлдвэрлэлийн бодит зардал болон ажиллагчдын хамаарал	20
Зураг II.1. Төсвийн орлого, зарлага, тэнцэл	23
Зураг II.2. Төсвийн төлөв тэнцэл, автомат тогтворжуулагч	24
Зураг II.3. Дэлхийн улс орнуудын мөнгөний болон төсвийн бодлого	24
Зураг II.4. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл	25
Зураг III.1. Инфляцын бүрэлдэхүүн	29
Зураг III.2. Тэйлорын хүү, мөнгөний зорилтот өсөлт, мөнгөний илүүдэл	30
Зураг III.3. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд	31
Зураг III.4. Зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд	32
Зураг III.5. Нийт хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн түвшин	33
Зураг III.6. Арилжааны банкнуудын ашигт ажиллагаа ба зохистой харьцааны үзүүлэлт	33
Зураг III.7. Хөрөнгийн зах зээл	34
Зураг IV.1. Гадаад худалдааны үзүүлэлт	38
Зураг IV.2. Гурилын үйлдвэрлэл, хэрэглээ	40
Зураг IV.3. Цементийн үйлдвэрлэл, хэрэглээ	41
Зураг IV.4. Урсгал дансны тэнцэл, гадаад валютын нөөц, төгрөгийн ханш	42
Зураг IV.5. Гадаад хөрөнгө оруулалтын позиц	43

Зураг IV.6.	Гадаад ер	44
Зураг IV.7.	Гадаад ерийн тогтвортой байдал	45

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт I.1.	Ядуурлын хамаарлын хүрээ	14
Хүснэгт II.1.	Монгол улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөл	26
Хүснэгт 0.1.	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	54
Хүснэгт 0.2.	Бодит секторын үзүүлэлтүүд	55
Хүснэгт 0.3.	Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд	56
Хүснэгт 0.4.	Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд	57
Хүснэгт 0.5.	Мөнгөний үзүүлэлтүүд	58

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ 1.	Хөдөө аж ахуйн салбар ба том малын зүй бус хорогдол	14
Шигтгээ 2.	Ядуурал	16
Шигтгээ 3.	Үйлдвэрлэлийн зардлын өсөлт болон ажиллагчдын тооны өсөлтийн хамаарал	21
Шигтгээ 4.	Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль	28
Шигтгээ 5.	Гурилын гаалийн татвар	42
Шигтгээ 6.	Цементийн гаалийн татвар	43

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГВУН	Гадаад валютын улсын нөөц
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨНЭЭС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа ба Хөгжлийн байгууллага

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

Эдийн засгийн дотоод идэвхжил, гадаад эрэлтийн өсөлт хадгалагдаж, Монгол Улсын эдийн засаг 2024 оны эхний улиралд 7.8 хувиар өслөө. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл тогтвортой нэмэгдэж, тээвэр, боловсруулах, барилга, үйлчилгээ зэрэг хөдөө аж ахуйгаас бусад салбарын өсөлт хадгалагдлаа. Нүүрс олборлолт 22 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 25 хувиар, төмрийн хүдэр олборлолт 1.5 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 63 хувиар тус тус өссөнөөр уул уурхайн салбар 13 хувиар тэлж, нийт эдийн засгийн өсөлтийн 1.9 нэгж хувийг бүрдүүлээ. Уул уурхайн салбарын идэвхжил тээврийн салбарын өсөлтийг дэмжиж, инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, хүнсний зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэнээр барилга, боловсруулах салбарын өсөлт хадгалагдлаа. Харин өвөлжилт, хаваржилт хүндэрч, том малын зүй бус хорогдол 2024 оны эхний улиралд 6.3 сая толгойд хүрснээр хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, экспорт, хөрөнгийн хуримтлал, ажилчдын тоо буурсан нь нийт эдийн засгийн өсөлтийг бууруулах нөлөө үзүүлээ.

Эдийн засгийн өсөлтийг сүүлийн 4 улирал дараалан гадаад эрэлт голлон дэмжсэн бол 2024 оны эхний улиралд дотоод эрэлтийн нөлөө давамгайллаа. Өрхийн цалингийн орлого нэмэгдэж, дундаж бодит орлого сайжирснаар хэрэглээ өслөө. Өрхийн бодит орлого сайжирч, хэрэглээ нэмэгдсэн нь худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийг тэтгэв. Хэдийгээр өрхийн бодит орлогын өсөлт нийслэлд эрчимжсэн ч хөдөө орон нутагт саарч байна. Ажиллагсдын тооны өсөлтийн нөлөөгөөр ажиллах хүч нэмэгдэж, нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн эзлэх хувь сүүлийн 5 жилийн дээд түвшинд хүрч нэмэгдлээ.

Уул уурхайн салбарын татварын орлогын өсөлт хадгалагдаж, төсвийн тэнцэл сүүлийн 5 улирал дараалан ашигтай гарлаа. 2023 оноос уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг дэмжих, хилийн боомтын дэд бүтцийг хөгжүүлэх, экспортыг эрчимжүүлэх, татварын бүртгэл, хамрагдалтыг сайжруулах чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд төсвийн тэнцэл 2024 оны эхний улирлын байдлаар 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Засгийн газар 2024 оны 3 дугаар сард “Хуралдай” бондын үлдэгдэл 53 сая ам.долларыг төлж, төсөвт үзүүлэх өрийн дарамтыг буурууллаа.

Инфляц төв банкны зорилтот интервалд хүрч буурч, банкнуудын хадгаламж, шинээр олгосон зээлийн хэмжээ нэмэгдлээ. Оны эхний улиралд импортын болон дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт саарч, инфляц 7 хувьд хүрснээр төв банк 15 сарын дараа мөнгөний бодлогын хүүг буурууллаа. Инфляцын түвшин буурч бодит хүү нэмэгдсэн, төгрөгийн ханш тогтвортой байсан нь өрхийн бодит орлогыг нэмэгдүүлж, нийт хадгаламжийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ. Арилжааны банкнуудын зээлийн эх үүсвэр нэмэгдсэнээр иргэд, аж ахуй нэгжид шинээр олгосон зээлийн хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 7.1 хувьд хүрч буурч, өөрийн хөрөнгийн хүрэлцээ сайжирснаар ашигт ажиллагааны үзүүлэлтүүд сайжирсан байна.

Импортын өсөлт экспортын өсөлтийг давсан ч гадаад валютын улсын нөөц нэмэгдэж, төгрөгийн ханш чангарлаа. Оны эхний улиралд нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн хэдий ч нүүрсний экспортын үнэ буурч, өвөлжилт, хаваржилтын хүндрэл хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортод сөргөөр нөлөөлснөөр нийт экспортын орлого өмнөх оны мөн үеэс буурлаа. Харин дотоод эдийн засгийн идэвхжил хадгалагдаж, өрхийн орлого, арилжааны банкнуудын зээл олголт нэмэгдэж, иргэд, аж ахуй нэгжийн худалдан авах чадвар сайжирсан нь импортын өсөлтийг өдөөж, гадаад худалдааны бараа эргэлт нэмэгдэхэд голлон нөлөөлөө. Экспортын орлогын бууралт, импортын өсөлтөөс шалтгаалан урсгал данс алдагдалтай гарсан ч шууд хөрөнгө оруулалт, зээлийн орох урсгал нэмэгдсэнээр төлбөрийн тэнцэл өмнөх оны мөн үеэс сайжирч, гадаад валютын нөөц нэмэгдэж, төгрөгийн ханш чангарлаа.

БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ

Эдийн засгийн өсөлт 2024 оны эцэст 6.0 орчим хувь байхаар төсөөлж байна. Оюутолгойн гүний уурхайн олборлолт үргэлжилснээр баяжмал дахь зэс болон алтны агууламж нэмэгдэнэ. Мөн нүүрс, алт, төмрийн хүдрийн олборлолт өссөнөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэхээр байна. Уул уурхайн салбарын дам нөлөөгөөр ачаа тээвэр өсөлттэй байх бол жуулчдыг татахад чиглэсэн арга хэмжээнүүд хэрэгжүүлснээр 2024 оны сүүлийн хагас жилд аялал жуулчлал, үйлчилгээний салбар өсөх хүлээлттэй байна. 2022 онд батлагдсан Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийн дагуу хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах тоног төхөөрөмжийн импортын татварыг тэглэснээр 2023 онд тоног төхөөрөмжийн импорт нэмэгдсэн. Уг нөлөөгөөр 2024 онд боловсруулах салбарын гарц нэмэгдэхээр байна. Харин цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас том малын зүй бус хорогдол 2023 оны түвшнээс давж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 2024 онд агшихаар байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэнээр өрхийн хэрэглээ өсөж, дотоод эрэлт сайжран, улмаар худалдаа, үйлчилгээний борлуулалт нэмэгдэн эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Гадаад худалдааны тэнцэл 2024 оны эцэст 6.1 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Хилийн боомтуудын дэд бүтцийг сайжруулах, тээвэр зохион байгуулалтыг оновчтой хийх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг өргөтгөх зэрэг экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн үр дүнд 2024 оны эцэст нүүрсний экспорт 78 сая тоннд, зэсийн баяжмал 1,560 мянган

тоннд, төмрийн хүдэр 8.4 сая тоннд газрын тос 4.2 сая баррельд хүрч, нийт экспортын дүн 17.4 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Харин өрхийн орлого, зээл олголт нэмэгдэж, эдийн засгийн өсөлт тогтвортой байснаар импорт 2024 оны эцэст 11.3 тэрбум ам.долларт хүрч өсөхөөр байна. Гэсэн хэдий ч Тяньжин боомт дээрх саатал нэмэгдвэл импортын нийлүүлэлт удаашрах эрсдэлтэй байна.

Инфляц төв банкны зорилтот түвшинд хадгалагдаж байна. Экспортын орлого нэмэгдэж, гадаад валютын зах зээл тогтвортой байснаар импортын гаралтай инфляцын дарамт бага байх хүлээлттэй байна. Харин өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамт хадгалагдах эрсдэл хэвээр байна.

Зарим дотоод болон гадаад эрсдэлүүд эдийн засгийн төлөвийг муутгаж болзошгүй байна. Нийт нутгийн дийлэнхийг хамарсан зудын улмаас хүнсний инфляц өсөх, малчдын амьжиргаа муудах, хөдөө аж ахуйн салбар үргэлжлэн агших эрсдэлтэй байна. Мөн Тяньжин боомт дээр үүсээд буй чингэлгийн саатал үргэлжлэх нь импортын нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Түүнчлэн дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлаас шалтгаалан манай улсын экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн үнэ болон эрэлт буурах, геополитикийн тогтворгүй байдлын улмаас авто бензин, улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг импортын голлох бараа бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дээрх үнэ нэмэгдэж, инфляцын дарамт нэмэгдэх эрсдэл бий.

БОДЛОГЫН ЗОРИЛТ

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогыг баримталж байна. Энэ хүрээнд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг боловсруулахад дараах бодлогын зорилтуудыг баримтлав.

Эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд 6-гаас дээш хувьд тогтвортой хадгална. Тус бодлогын хүрээнд уул уурхай болон хөдөө аж ахуйн салбарын экспортыг нэмэгдүүлэх, тээвэр логистик, аялал жуулчлал зэрэг үйлчилгээний салбарын үйл ажиллагааг идэвхжүүлэх, либералчлах бодлогыг хэрэгжүүлнэ. Цаашид Оюутолгойн гүний уурхайн эрдсийн өндөр агуулгатай баяжмал үйлдвэрлэл болон бусад уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт нэмэгдэж, худалдааны түнш улс орнуудтай хийж буй худалдааны хэлэлцээрүүдийн хүрээнд хөрөнгө оруулалт, экспорт тогтвортой өсөх нь тус бодлогын суурь юм.

Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах, өрхүүдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд инфляцыг бууруулж, дунд хугацаанд 5 орчим хувьд хүргэнэ. Инфляцыг бууруулахад хөдөө аж ахуйн салбарт цогц шинэчлэл хийж, хүнсний нийлүүлэлтийг сайжруулах, экспорт, импорттой холбоотой зохицуулалтыг оновчтой хийж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлж импортын гаралтай инфляцыг бууруулах, төсвийн алдагдлыг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. **Экспортын орлогыг нэмэгдүүлж, гадаад валютын улсын нөөцийг 10 тэрбум ам.долларт хүргэнэ.** Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр экспорт, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, ашигт малтмалын олборлолт, боловсруулалт, тээвэрлэлтийн

ил тод байдлыг хангах, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл тасралтгүй хөгжүүлэх зэрэг арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг 2025 онд -2.0 хувь, 2026 онд -1.5 хувь, 2027 онд -1.0 хувь болгон бууруулж, цаашид төсөв алдагдалгүй байх бодлого баримтална. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байлгана гэж заасны дагуу 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг хоёр хувьд хүргэж, цаашид алдагдлыг үе шаттай бууруулах бодлого баримтална.

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг үе шаттайгаар бууруулан 2025 онд 50 хувь, 2026 онд 45 хувь, 2027 онд 40 хувьд хязгаарлана. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсвийн тусгай шаардлагад Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байна гэж заасан байдаг. Уул уурхайн салбарын сэргэлт болон түүнийг дагасан тээвэр, үйлчилгээний салбарын өсөлтийн нөлөөгөөр төсөв ашигтай гарч, өрийн түвшинг бууруулах нөхцөл бүрдээд байна. Иймд Засгийн газраас эдийн засагт дарамт үүсгэхгүй, зээлжих зэрэглэлийг муутгахгүй түвшинд хүргэх зорилгоор Засгийн газрын өрийн хэмжээ болон ДНБ-ий харьцааг 2027 он гэхэд 40 хувьд хүртэл үе шаттай бууруулах зорилтыг 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд тусгасан болно.

БҮЛЭГ I

БОДИТ СЕКТОР

- 1.1 НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ
- 1.2 НИЙТ ЭРЭЛТ
- 1.3 ХӨДӨЛМӨР БА БИЗНЕС
- 1.4 ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГ

I. БОДИТ СЕКТОР

ТОЙМ

Эдийн засаг тогтвортой өсөлтийг хадгалах зорилттой нийцтэй буюу 7.8 хувиар өслөө. Сүүлийн 4 улиралд эдийн засгийн өсөлтийг гадаад эрэлт голлон дэмжсэн бол 2024 оны эхний улиралд дотоод эрэлт эдийн засгийн өсөлтийг тайлбарлаж байна. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг хувь нэмэр орууллаа. Уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт нэмэгдэн салбарын үйлдвэрлэл, экспортын хэмжээ нэмэгдсэн ба үүнийг дагаад тээврийн салбар өслөө. Инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, хүнсний зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нөлөөгөөр барилга, боловсруулах салбарын өсөлт хадгалагдсан бол өрхийн бодит орлого сайжирч, хэрэглээ нэмэгдсэн нь худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийг тэтгэв. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, зээлийн өсөлт эрчимжиж, эдийн засаг дахь хөрөнгийн хуримтлал өсөхийн зэрэгцээ хөдөлмөр эрхлэлт сайжирснаар эдийн засгийн нийт үйлдвэрлэл потенциал түвшин рүү ойртож байна.

Цаашид өсөлтийг хадгалах хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хувийн секторын үйл ажиллагааг дэмжих чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ

1. Хөдөө аж ахуйгаас бусад салбарууд тэлж, эдийн засгийн өсөлт эрчимжлээ. 1.Нэрлэсэн ДНБ 2024 оны эхний улиралд 16.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 6.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар тус тус өслөө. Хөдөө аж ахуйн салбараас бусад салбаруудын үйлдвэрлэл өсөлттэй байлаа. Цаашид хөдөө аж ахуйгаас бусад дотоод эдийн засгийн идэвхжил, уул уурхайн салбарын дам нөлөө эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна. Эдийн засгийн бүтцийг салбараар нь авч үзвэл, 28¹ хувийг уул уурхай, 16 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, 10 хувийг хөдөө аж ахуй, 9 хувийг боловсруулах, 6 хувийг тээвэр, 5 хувийг барилга болон цахилгаан, усан хангамж, үлдсэн 26 хувийг үйлчилгээний бусад 11 салбар бүрдүүлж байна.

2. Нүүрс, төмрийн хүдрийн олборлолт өссөнөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэл тогтвортой нэмэгдэж, 2024 оны эхний улиралд уул уурхайн салбарын өсөлт төсөөлөлттэй нийцтэй байв. Уул уурхайн салбар 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 13 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 1.9 нэгж хувийг бүрдүүллээ. Үүнд нүүрс олборлолт 22 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 25 хувиар, төмрийн хүдэр олборлолт 1.5 сая тоннд хүрч 63 хувиар тус тус өссөн нь голчлон нөлөөлөв. Харин зэсийн баяжмалын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеийн түвшинтэй ойролцоо байгаа бол алт болон газрын тос олборлолт харгалзан 5 болон 10 хувиар тус тус буурсан байна. Уул уурхайн салбарын өсөлт төсөөлөлттэй нийцтэй байв.

3. Нүүрсний экспорт нэмэгдсэн нөлөөгөөр тээврийн салбарын өсөлт өндөр хэвээр байв. Ачаа тээвэр 2024 оны эхний улиралд 34.3 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 42 хувиар нэмэгдсэнээр тээврийн салбарын үйлдвэрлэл 27 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийг 1.3 нэгж хувиар дэмжлээ. Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, дотоодоос гарах ачаа тээврийн хэмжээ өсөхийн зэрэгцээ бараа, бүтээгдэхүүний импорт өссөнөөр ачаа тээврийн орох урсгал мөн нэмэгдлээ. Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хүрээнд төмөр замын тарифын мөрдлөгт ачаа тээврийн 16, зорчигч тээврийн 2 бүлгийн үнэ, тарифт өөрчлөлт оруулсан. Мөн БНХАУ-ОХУ чиглэлийн дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн тарифын хөнгөлөлтийг 61 хувиас 51 хувь болгон бууруулж, үнийн либералчлалыг эхлүүлсэн. Үүний үр дүнд нийт тээвэрлэсэн ачаа нэмэгдсэнээс гадна төмөр замын тариф ашигтай түвшинд хүртэл нэмэгдэж, тээврээс олох нийт орлого 41 хувиар өслөө.

4. Бүх төрлийн ундаа, спирт, усны үйлдвэрлэл нэмэгдсэнээр боловсруулах салбар өслөө. Боловсруулах салбар 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг 0.4 нэгж хувиар дэмжлээ. Тус салбарын 30 орчим хувийг бүрдүүлдэг ундааны² үйлдвэрлэл 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 43.5 хувиар, 7 орчим хувийг бүрдүүлдэг сүүний үйлдвэрлэл 0.1 хувиар тус тус өсөж, салбарын өсөлтийг тэтгэлээ. Харин махны боловсруулах үйлдвэрлэл өвөлжилт,

¹ 2023 оны урьдчилсан гүйцэтгэлд үндэслэн тооцов. Эх сурвалж: ҮСХ, ЭЗХЯ-ны тооцоолол

² Согтууруулах ундааг оруулснаар

хаваржилтын хүндрэлээс шалтгаалж 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 9 хувиар буурлаа. Түүнчлэн, цахилгаан, дулаан, ус хангамжийн үйлдвэрлэл 7.7 хувиар өсөж, өсөлтийн 0.4 нэгж хувийг бүрдүүлсэн байна.


5. Инженерийн дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтууд барилгын салбарт эерэг нөлөө үзүүлээ. Амгалан ДЦС, Чойбалсан ДЦС-ын хэрэгжилтийн түвшин 2023 оны 10 дугаар сард тус тус 56.3 хувь, 81.3 хувийн гүйцэтгэлтэй байсан бол 2024 оны эхний улиралд бүтээн байгуулалтын ажил дуусах шатанд орж, 2024 оны 4 дүгээр сард тус тус 93 хувь, 94 хувийн гүйцэтгэлтэй байна. Улмаар нийт барилгын салбар 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 27.7 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 0.2 нэгж хувийг бүрдүүллээ. Барилга, байгууламжийн ажлыг бүтээн байгуулалтын төрлөөр авч үзвэл инженерийн барилга өмнөх оны мөн үеэс 4.5 дахин, орон сууцны бус барилга 30 хувиар тус тус өссөн байна.

6. Үйлчилгээний салбарын үйл ажиллагаа 7.7 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Үйлчилгээний салбарт бөөний болон жижиглэн худалдаа, тээвэр, мэдээлэл холбоо болон үйлчилгээний бусад салбарууд багтдаг. 2024 оны эхний улиралд дотоодын эдийн засгийн идэвхжил, өрхийн хэрэглээ нэмэгдсэнээр үйлчилгээний салбарын дийлэнхийг бүрдүүлдэг бөөний болон жижиглэн худалдааны салбар төсөөллөөс бага

зэрэг давж 6.5 хувиар өсөв. Өрхийн хүнсний бус хэрэглээний зардал, хэрэглээний импорт нэмэгдэж, хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа 19 хувиар өссөн нь нийт худалдааны борлуулалтад эергээр нөлөөлжээ. Мөн мэдээлэл, холбооны салбар 26.3 хувиар, үйлчилгээний бусад салбаруудын гарц 3.7 хувиар тэлсэн байна.

7. Том малын зүй бус хорогдол 6.3 сая толгойд хүрч хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг хязгаарлалаа. Том малын зүй бус хорогдол 2024 оны эхний улиралд 6.3 сая толгойд хүрч, өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгой малаар нэмэгдсэнээр хөдөө аж ахуйн салбар өмнөх оны мөн үеэс 31.4 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 1.3 нэгж хувиар хязгаарлалаа. (Том малын зүй бус хорогдлын талаар Шигтгээ 1-ийг үзнэ үү.)

Зураг I.1 Бодит ДНБ-ий өсөлт




ШИГТГЭЭ 1. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР БА ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хөдөө аж ахуйн салбар 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 31.4 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 1.3 нэгж хувиар хязгаарлалаа. Хөдөө аж ахуйн салбар нь уул уурхайн салбарын дараа ордог буюу Монгол Улсын эдийн засгийн 13 хувийг бүрдүүлдэг салбар юм. Тус салбарын 91 хувийг мал аж ахуй, 9 хувийг газар тариалангийн салбар тус тус бүрдүүлж байна. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь цаг уурын өөрчлөлтөөс өндөр хамааралтай байдаг тул үйлдвэрлэлийн гарц өндөр хэлбэлзэлтэй байдаг. Өнгөрсөн 2023-2024 оны өвөл нийт нутгийн 90 гаруй хувьд цасан бүрхүүлтэй, өвлийн туршид огцом дулаарал болон хүйтрэл ажиглагдсаны улмаас 14 аймгийн 46 суманд мөсөн (төмөр) зуд, харин говийн аймгийн зарим сумдын нутгаар зундаа гантай байснаас харын зудын нөхцөл тус тус үүссэн¹. Өвөлжилтийн хүндрэлээс шалтгаалан 2023 оны жилийн эцэст өмнөх оноос 6.4 сая толгойгоор бага мал буюу 64.7 сая толгой мал тоологдсон бол 2024 оны эхний улиралд 6.3 сая толгой мал хорогдож, 2023 оны эцэст тоологдсон малын 9.8 хувьтай тэнцлээ. Хорогдсон том малын 65.7 хувийг нийт малын 30 хувийг бүрдүүлдэг Архангай, Төв, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь аймгууд бүрдүүлсэн байна.


Зураг 1.2 Том малын зүй бус хорогдол

1. Том малын зүй бус хорогдол, өссөн дүнгээр, улирлаар (сая толгой)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2. Том малын зүй бус хорогдол, (аймгаар, сая толгой)



Powered by Bing
© GeoNames, TomTom, Wikipedia


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ТӨСӨӨЛӨЛ

2024 оны жилийн эцэст том малын зүй бус хорогдол 13.1 сая толгойд хүрч, нийт малын тоо толгой 2015-2016 оны түвшинтэй ижил түвшинд хүрэх төлөвтэй байна. Хорогдлын хэмжээг байршлаар харвал Сүхбаатар, Хэнтий, Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Увс аймгуудад малын хорогдол өндөр байх төлөвтэй байгаа ба сүүлийн 50 гаруй жилд тохиолдсон хамгийн өндөр хорогдол болох эрсдэлтэй байна.


Зураг 1.3 Том малын зүй бус хорогдлын 2024 оны төсөөлөл

1. Том малын зүй бус хорогдол, өссөн дүнгээр, жилээр (сая толгой)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Үндэсний статистикийн хороо

2. 2024 оны том малын зүй бус хорогдлын төсөөлөл (аймгаар, сая толгой)



Powered by Bing
© GeoNames, TomTom, Wikipedia

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Том малын зүй бус хорогдолд үзүүлэх өвөлжилт, хаваржилтын хүндрэлийн нөхцөл байдлын төлөөлөх хувьсагчаар 2008 – 2023 оны нэгдүгээр сараас гуравдугаар сарын дундаж хур тунадасны нийлбэр хэмжээг сонгон авч сүргийн эргэлтийн тооцоолоор 2024 оны том малын зүй бус хорогдлын хэмжээг төсөөлөв.

¹ 2023-2024 оны мал өвөлжилтийн цаг агаарын нөхцөлийн тойм <http://wtsaga-agaar.gov.mn>

8. Дотоод эрэлт хүлээлтээс давж, эдийн засгийн өсөлтөд гол нөлөө үзүүлээ. Эцсийн хэрэглээ 2024 оны эхний улиралд 25.6 хувиар өсөж, бодит дүнгээр 2020 оны нэгдүгээр улирлаас хойш анх удаа ДНБ-ийг давлаа. Засгийн газар 2023 оны 7 дугаар сараас тэтгэвэр, тэтгэмж болон төрийн албан хаагчдын цалинг 26-50 хувиар өсгөсөн нь төрийн хэрэглээг өмнөх оны мөн үеэс 47.1 хувиар нэмэгдүүлэх голлох нөлөөг, мөн өрхийн хэрэглээг 20.1 хувиар нэмэгдүүлэх дам нөлөөг үзүүлэн, улмаар дотоод эрэлтийг идэвхжүүлээ. Цаашид эдийн засаг тогтвортой байж, төсвийн томоохон хөрөнгө оруулалтуудын нөлөө болон мөнгөний бодлогыг сулруулсны нөлөөгөөр дотоод эрэлт эрчимжих төлөвтэй байна.

9. Өрхийн хэрэглээ төдийгүй иргэдийн хадгаламж нэмэгдэж байгаа нь эрэлтийн цаашдын төлөвийг дэмжихээр байна. Иргэдийн хадгаламж 2022 онд 15.0 их наяд төгрөг болж буурсан бол 2024 оны эхний улирлын байдлаар 18.8 их наяд төгрөг болж, түүхэн дээд түвшинд хүрлээ. Түүнчлэн арилжааны банкны зээл олголт өсөж, иргэдийн зээл оны эхний улирлын байдлаар 17.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 38.2 хувиар нэмэгдсэн нь өрхийн хэрэглээг дэмжиж байна. Өрхийн хүнсний хэрэглээ 3.3 хувиар өссөн бол хувцас, тавилга зэрэг хүнсний бус бараа, бүтээгдэхүүний хэрэглээ өмнөх оны мөн үеэс 32.1 хувиар, тээвэр, харилцаа холбоо зэрэг үйлчилгээнд зарцуулсан зардал 29.7 хувиар өссөн нь иргэдийн эдийн засагт итгэх итгэл дээшилж байгааг илтгэж байна. Тухайлбал оны эхний улиралд өрхийн тээвэр, зочид буудал, аялал, амралтын үйлчилгээтэй холбогдох зардал нэлээдгүй өссөн. Мөн гадаадад зорчсон Монгол иргэдийн тоо 220 мянга буюу 64 хувиар нэмэгдсэн нь өвлийн улиралд болон цагаан сарын баярын амралтаар хилийн чанадад зорчих иргэдийн тоо нэмэгдэж байгааг харуулж байна.

10. Өрхийн бодит орлого 19.8 хувиар сайжирлаа. Инфляц төв банкны зорилтот интервалд хадгалагдан, төгрөгийн ханш тогтвортой байгаа нь өрхийн орлогод

эерэг нөлөө үзүүлж байна. Өрхийн орлого нэрлэсэн дүнгээр 2.4 сая төгрөг болж өсөхөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс 21.9 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Тэтгэвэр, тэтгэмж, халамжийн хэмжээ, төрийн албан хаагчдын цалинг нэмсэн, түүнчлэн эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр хөдөлмөр эрхлэлт 2024 оны эхний улиралд 56.3 хувьд хүрч өссөн нь өрхийн цалингийн орлогыг дэмжлээ. Цалингийн орлого цар тахлын өмнө жилүүдэд өрхийн орлогын 54 орчим хувийг бүрдүүлж байсан бол цар тахлын үеэр өрхийн халамж, тэтгэмжийн орлого нэмэгдсэний нөлөөгөөр 48 орчим хувь болж буурч байв. Харин 2024 оны эхний улирлын байдлаар өрхийн орлогын 57 хувийг цалингийн орлого бүрдүүлж, энэ төрлийн орлого сэргэснийг харуулж байна. Төрийн албан хаагчдын цалинг энэ оны 4 дүгээр сард дахин нэмэгдүүлснээр цалингийн өсөлт оны эцэс хүртэл хадгалагдах хүлээлттэй байна.

11. Орлогын өсөлт нийслэлд эрчимжиж байгаа бол хөдөө орон нутагт саарч, орлогын тэгш бус байдал нэмэгдэж байна. Улсын хэмжээнд нийт 983 мянган өрх бүртгэлтэй байгаагаас 465 мянга буюу 47 хувь нь нийслэлд, 210 гаруй мянга буюу 21 хувь нь бусад хот сууринд, үлдсэн 32 хувь нь хөдөөд амьдарч байна. Хот суурины өрхийн орлогын 60 орчим хувь нь цалингийн орлогоос бүрдэж байгаа бол хөдөөгийн малчин өрхийн орлогын тал нь мал аж ахуйн үйлдвэрлэлээс ордог байна. Мал аж ахуйн орлого нь улирлын шинж чанартай, цаг уурын нөхцөл байдлаас өндөр хамааралтай. Тухайлбал, малчид 2023 онд цаг уурын хүндрэлийг хохирол багатай даван туулах үүднээс их хэмжээгээр мал нядалсны үр дүнд 2023 оны сүүлийн хагаст хөдөөгийн өрхийн мал аж ахуйн орлого өсөх хандлага ажиглагдсан бол зуднаар олон тооны мал хорогдсоноор 2024 оны эхний улиралд хөдөөгийн өрхийн мал аж ахуйн орлого эргэн буурсан байна. Мал аж ахуйгаас хараат, цалингаас хамааралгүй малчдын орлого тогтворгүй хэвээр байна.

ШИГТГЭЭ 2. ЯДУУРАЛ

Цар тахлын хөл хорионы нөлөөгөөр хөдөлмөр эрхлэлт буурч, бизнесийн үйл ажиллагаа хумигдан, геополитикийн хурцадмал байдал үүссэнээр инфляц 2021 оны сүүлээс 2023 оны дунд үе хүртэл тогтмол хоёр оронгийн түвшинд хадгалагдаж, төгрөгийн ханш суларсан нь иргэдийн амьжиргааг дордуулж, өрхүүдийн бодит орлогыг муутган, ядуурлын эрсдэлийг нэмэгдүүлээд байв.

2022 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 27.1 хувь нь ядуурлын шугамаас¹ доогуур амьжиргаатай байна. Ядуурлын хамралт 2010 оноос 11.7 нэгж хувиар, 2018 оноос 1.3 нэгж хувиар, 2020 оноос 0.7 нэгж хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Дэлхий нийтэд ядуурал урт хугацаанд буурч байгаа ч бууралтын хурд улс орнуудад харилцан адилгүй байна. 2022 оны байдлаар дэлхийн нийт хүн амын 45.5 хувь нь өдөрт 6.85-аас бага ам.доллар зарцуулж, ядуу амьдарч байгаа бол уг үзүүлэлт БНХАУ-д 24.7 хувь, ОХУ-д 4.1 хувь, Вьетнамд 19.7 хувь, Казахстанд 10.6 хувь, Монгол Улсад 22.1 хувь байгаа юм.²

Хүснэгт 1.1 Ядуурлын хамаарлын хүрээ

	2010	2012	2014	2016	2018	2020	2022*
Улсын дундаж	38.8	27.4	21.6	29.6	28.4	27.8	27.1
Хот	33.2	23.3	18.8	27.1	27.2	26.5	23.0
Хөдөө	49.0	35.4	26.4	34.9	30.8	30.5	35.6
Бүс							
Баруун	52.7	32.3	26.0	36.0	31.8	31.5	36.5
Хангай	51.9	38.5	25.3	33.6	30.8	31.4	33.5
Төв	29.9	28.2	22.2	26.8	26.1	25.2	24.6
Зүүн	42.3	33.4	31.4	43.9	37.4	33.3	35.3
Сууршил							
Улаанбаатар	31.2	19.9	16.4	24.8	25.9	25.4	21.6
Аймгийн төв	37.3	30.4	23.8	31.8	30.1	29.1	26.1
Сумын төв	39.7	27.5	24.7	32.3	28.9	30.5	30.6
Хөдөө	56.1	39.6	27.9	38.0	32.9	30.5	41.2

Ядуурал хотод буурч, хөдөөд нэмэгдэн, бүс, орон нутгийн хувьд харилцан адилгүй байна. 2022 оны байдлаар нийслэлд 100 хүн тутмын 22 нь, аймгийн төвд 26 нь, сумын төвд 31 нь, хөдөөд 41 нь ядуу амьдарч байна. Ядуурал 2020-2022 онд нийслэл, аймгийн төвд буурч, сум, хөдөөд өссөн. Орон нутагт эдийн засгийн үйл ажиллагаа хумигдмал, инженерийн дэд бүтэц, ундны ус, интернэт хангамж хангалтгүй зэрэг амьдралын чанар муугийн дээр иргэдийн орлого мал аж ахуйгаас хараат байгаа нь хөдөөд ядуурал нэмэгдэх, хөдөөгийн иргэд илүү ядууралд өртөхөд хүргэж байна.

Орлогын тэгш бүс байдал нэмэгдэж байна. Эдийн засгийн салбар, орон зайн хувьд хэт төвлөрөл нэмэгдэж, бүс орон нутгийн хөгжлийн ялгаа ихсэж байна. Ядуурал төвөөс алслагдсан баруун бүсэд хамгийн өндөр буюу 36.5 хувьтай байгаа бол эдийн засаг, худалдаа төвлөрсөн төвийн бүсэд хамгийн бага буюу 24.6 хувь байна. Түүнчлэн ҮСХ-ноос 2018 оны ӨНЭЗС-ны үр дүнгээр хамгийн өндөр орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого хамгийн бага орлоготой өрхүүдийн сарын дундаж орлогоос 5.6 дахин их байсан бол уг харьцаа 2022 оны судалгаагаар 7 дахин их болж өссөн нь орлогын тэгш бүс байдал нэмэгдэж байгааг харуулж байна.

¹ Ядуурлын шугам хүний эрүүл идэвхтэй амьдралыг хангахуйц илчлэгтэй, хоол шаардлагатай бараа үйлчилгээний хэрэгцээг тусгасан хэрэглээний хамгийн бага зардал юм. Монгол Улсын ядуурлын шугам 2022 оны байдлаар 418,090 төгрөг байна.

² Дэлхийн банкны 2017 оны олон улсын худалдан авах чадвараар илэрхийлэгдсэн 6.85 ам.доллаароор зэрэгцүүлсэн үзүүлэлт.


*2022 оны ядуурлын тооцоо ядуурлын шугамын шинэчлэгдсэн аргачлалаар хийгдсэн

12. Хөрөнгө оруулалт өссөн ч том малын зүй бус хорогдол нэмэгдэж, үндсэн хөрөнгийн хуримтлал 5.4 хувиар буурлаа. Хөрөнгийн хуримтлал нэмэгдэх нь урт хугацаанд эдийн засгийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг тэлэх нөлөөтэй. Үндсэн хөрөнгийн хуримтлалд машин тоног төхөөрөмж, орон сууцны болон орон сууцны бус барилга байгууламж, дэд бүтэц, том мал, оюуны өмч зэрэг бараа, үйлчилгээ үйлдвэрлэхэд шаардлагатай хөрөнгөд гарсан өөрчлөлтийг бүртгэдэг. Оны эхний 3 сарын байдлаар шинээр олгосон зээл өмнөх оны мөн үеэс 37.0 хувиар, гадаадын шууд хөрөнгө оруулалт 2.2 дахин, төсвийн хөрөнгө оруулалт 72.3 хувиар тус тус нэмэгдлээ. Тухайлбал, аж ахуй нэгж байгууллагад олгосон зээлийн хэмжээ 5.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 42.0 хувиар, зээлийн үлдэгдэл 11.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар тус тус өссөн байна. Санхүүжилт нэмэгдэх нөлөөгөөр инженерийн барилга байгууламж 73.2 хувиар, орон сууцны барилга 6.4 хувиар, машин тоног төхөөрөмж 22.1 хувиар, оюуны өмч 2 дахин

тус тус нэмэгдсэн ч Монгол Улсын 14 аймгийн ихэнх сумдад тохиосон зудын уршгаар улсын хэмжээнд том мал ихээр хорогдсон нь үндсэн хөрөнгийн хуримтлалыг буурууллаа. Цаашид зээл олголт нэмэгдэж, эдийн засаг дах хөрөнгийн хуримтлалыг дэмжих төсөөлөлтэй байна.

13. Импорт 10.8 хувиар өссөнөөр гадаад тэнцэл эдийн засгийн өсөлтийг 19.4 нэгж хувиар буурууллаа. Төгрөгийн ханш чангарч, импортын бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжсон нь хэрэглээний болон хөрөнгө оруулалтын бараа, бүтээгдэхүүний импортын өсөлтийг идэвхжүүллээ. Өмнөх оны мөн үеэс барааны импорт 24.4 хувиар өслөө. Хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импорт 30.1 хувиар өссөн нь нийт барааны импортын өсөлтөд хамгийн өндөр нөлөө үзүүлж, гадаад тэнцвэрт сөрөг нөлөө үзүүлэв. Хэрэглээний бараа, бүтээгдэхүүний өсөлтөд суудлын автомашин болон АИ-92 бензиний импорт голлож байна.

Зураг I.4. Өсөлтийн бүтэц



ХӨДӨЛМӨР БА БИЗНЕС


14. Эдийн засгийн өсөлт хөдөлмөрийн зах зээлийн идэвхжилийг дэмжлээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2024 оны эхний улиралд ажилчдын тоо 3.0 хувиар өсөж 1,294 мянган хүн, ажиллах хүч 2.4 хувиар өсөж 1,365 мянгад хүрлээ. Энэ нь цар тахлын өмнөх жилтэй харьцуулахад ажилчдын тоо 151 мянган хүн, ажиллах хүч нь 99 мянган хүнээр тус тус өссөн үзүүлэлт юм. Улмаар ажиллах хүчний оролцооны түвшин 59.4 хувьд хүрч, хүлээлтээс 2.0 нэгж хувиар давлаа.

15. Ажилчдын тооны өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбар эерэг нөлөө үзүүлээ. Дотоодын эдийн засаг идэвхжиж, өрхийн хэрэглээ нэмэгдсэнээр 2024 оны эхний улиралд худалдааны салбарын ажилчдын тоо 15.2 хувиар, үйлчилгээний салбарын ажилчдын тоо 31.3 хувиар тус тус өслөө. Мөн уул уурхай болон уул уурхайн салбарыг дагасан тээврийн

салбарын өсөлтийн нөлөөгөөр уул уурхай, тээврийн салбарт ажиллагчдын тоо харгалзан 20.4 хувь, 56.8 хувиар тус тус өслөө. Харин өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсний улмаас хөдөө аж ахуйн салбарын ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 31 хувиар буюу 140 мянган хүнээр буурч, 312 мянгад хүрсэн байна.

16. Эрэгтэй ажилчдын тоо эрчимтэй нэмэгдлээ. Ажилчдын тоог хүйсээр авч үзвэл, оны эхний улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 32 мянган хүнээр нэмэгдэж, 702 мянгад хүрсэн бол эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 1 хувиар буюу 5.9 мянгаар өсөж 591 мянгад хүрсэн байна. Уул уурхай, тээвэр, боловсруулах салбарын идэвхжил бусад салбараас өндөр байсан нь эрэгтэй ажилчдын тооны өсөлт эмэгтэй ажилчдаас илүү хурдтай өсөхөд нөлөөлсөн байна.

Зураг 1.5. Хөдөлмөрийн зах зээл




17. Ажил идэвхтэй хайж байгаа иргэдийн тоо хөдөө, орон нутагт өсөж, Улаанбаатар хотод буурлаа. Ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар буурч 5.2 хувьд хүрсэн бол ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 7 мянган хүнээр буурч, 933 мянгад хүрсэн байна. Хот хөдөөгөөр ангилан харвал, Улаанбаатар хотод хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн тоо 74 мянган хүнээр нэмэгдсэнээр ажилгүй иргэдийн тоо 15 мянгаар буурч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо 29 мянгаар буурсан байна. Харин хөдөөд ажиллагчдын тоо 9 мянган хүнээр буурснаар, ажилгүй иргэдийн тоо 9 мянган хүнээр өсөж, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 23 мянган хүнээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

18. Нийт хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөд уул уурхайн салбар голчлон нөлөөллөө. Хөдөлмөрийн бүтээмж буюу нэг ажилтанд ногдох ДНБ-ий хэмжээ өмнөх оны мөн үеэс 217 мянган төгрөгөөр буюу 5 хувиар өсөж, 4,436 мянган төгрөгт хүрлээ. Бүтээмжийг салбараар задлан харвал, уул уурхайн салбар 4.4 хувиар өссөн бол хөдөө аж ахуйн салбар 3.1 хувиар, аж үйлдвэрийн салбар 10.6 хувиар, үйлчилгээний салбар 11.6 хувиар тус тус буурсан байна.

19. Дотоод эдийн засгийн идэвхжил, гадаад эрэлтийн өсөлт ААН-ийн үйл ажиллагааг идэвхжүүллээ. 2024 оны эхний улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо 97.8 мянгад хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар өслөө. Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 2.2 мянгаар, тэр дундаа үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн 76 хувийг бүрдүүлдэг бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 1.8 мянгаар нэмэгдсэн байна. Уул уурхайн экспортын өсөлтийн нөлөөгөөр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо уул уурхай салбарт 41, тээврийн салбарт 258-аар нэмэгдлээ. Түүнчлэн, хөдөө аж ахуйн салбарт 248 ААН шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсний 116 нь газар тариалан, 74 нь мал аж ахуй, 39 нь мод тарих үйл ажиллагаанд хамаарч байна. Мөн боловсруулах үйлдвэрлэлд 403 ААН, барилгын салбарт 454 ААН шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Зураг 1.6. Бизнес регистр



ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГ

20. Хөрөнгө оруулалтын голлох нөлөөгөөр потенциал үйлдвэрлэлийн өсөлт хадгалагдлаа.

2024 оны эхний улиралд том малын зүй бус хорогдол 6.3 сая толгойд хүрснээр үндсэн хөрөнгийн хуримтлал буурсан ч гадаадын шууд хөрөнгө оруулалт, төсвийн хөрөнгө оруулалт дагасан барилга, байгууламжийн өсөлт болон машин, тоног төхөөрөмжийн импортын өсөлтийн нөлөөгөөр потенциал өсөлт 4 хувь орчимд хадгалагдлаа.

21. Дотоод эдийн засгийн идэвхилийн нөлөөгөөр үйлдвэрлэлийн сөрөг зөрүү багасаж, нийт үйлдвэрлэлийн потенциал түвшинд ойртох хандлага хадгалагдлаа.


Оны эхний улиралд уул уурхайн олборлолт, хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр дотоод эдийн засгийн идэвхжил хадгалагдан аж үйлдвэр, худалдааны салбаруудын үйлдвэрлэл өссөнөөр үйлдвэрлэлийн сөрөг зөрүү алгуур хумигдаж, нийт үйлдвэрлэл потенциал

түвшнээсээ 0.5 нэгж хувиар доогуур байна.

22. Үйлдвэрлэлийн сөрөг зөрүү багасаж, төгрөгийн ханш чангарч, үйлдвэрлэлийн орцын зардал буурснаар ААН-ийн үйл ажиллагааны идэвх сайжирч байна.

Үйлдвэрлэлийн бодит ахиу зардал³ нь үйлдвэрлэл явуулахад шаардлагатай нэгж хөдөлмөрийн зардал болон орцын зардлыг илэрхийлэгч төлөөлөгч хувьсагч юм. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн зардал буурахад нэгж хөдөлмөрийн зардал буурч, ААН-үүд ажиллагчдаа нэмэгдүүлдэг бол уг зардал өсөхөд ажиллагчдын тоо буурах хамаарал ажиглагддаг.⁴ Тайлант улиралд төгрөгийн ханш өмнөх оны мөн үеэс 3 хувиар чангарч, аж үйлдвэрийн орцын импорт нэмэгдлээ. Ханшийн чангарлыг даган үйлдвэрлэлийн бодит ахиу зардал өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар буурч, үйл ажиллагаа явуулж буй ААН болон ажиллагчдын тоо өслөө.

Зураг 1.7. Үйлдвэрлэлийн зөрүү



³ Тооцоолол дох үйлдвэрлэлийн бодит ахиу зардал нь бараа, үйлчилгээг үйлдвэрлэх дотоодын болон импортын орцын зардлын өсөлтийн хувийг илэрхийлнэ. Тус зардал нь Мөнгөний бодлогын шинжилгээний GAP загварын Филиппсийн муруйн тэгшитгэлээр тооцоолон гаргасан ойролцоо дүн болно.

⁴ (Galí Jordi 1999), (Argia 2002) нарын эмпирик судалгаа нь АНУ болон Европын улс

орнуудад Шинэ Кэйсийн филиппсийн муруйн тэгшитгэл дэх үйлдвэрлэлийн бодит ахиу зардлыг нэгж хөдөлмөрийн зардлаар төлөөлүүлэн хамаарлыг шинжилсэн.

⁵ Үйлдвэрлэлийн зөрүүг бодит болон потенциал ДНБ-ий зөрүүгээр тооцно.
⁶ 2024 оны эхний улирлын ажиллагчдын тоог ҮСХ-ны дарга, ХНХ-ын сайдын 2019 оны 01 сарын 17-ны едрийн А-09/А-08 дугаар тушаалаар батлагдсан аргачлалаар тооцон, олон нийтэд зарласан статистикийг ашиглав.

ШИГТГЭЭ 3. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗАРДЛЫН ӨСӨЛТ БОЛОН АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨСӨЛТИЙН ХАМААРАЛ

Филипсийн муруй ба үйлдвэрлэлийн ахиу зардал

Инфляц нь бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшний өөрчлөлтийг илэрхийлдэг бол ажил эрхлэлт/ажиллагчид нь хөдөлмөр эрхэлж, хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож буй хүмүүсийг илэрхийлдэг. Эдгээрийн хамаарал нь эдийн засгийн ухааны өргөн хүрээний судалгааны сэдэв болдог. Хөдөлмөр, инфляцын хоорондох хамаарлын талаар эдийн засгийн хэд хэдэн ялгаатай онол, хандлагууд байдгийн дотор шинэ Кэйнсийн эдийн засагчдын боловсруулсан эрэлт, нийлүүлэлтийн талын огцом өөрчлөлтийг тусгасан Филипсийн муруй нь (инфляцын тэгшитгэл) чухал байр суурийг эзэлдэг. Филипсийн муруй нь нэрлэсэн хувьсагчийн (цалин, үнэ) хөшүүн байдлаар дамжуулан хөдөлмөрийн зах зээлийг авч үздэгээрээ онцлогтой. Нэрлэсэн хувьсагчийн хөшүүн байдлын талаарх эмпирик судалгааг сайжруулахын тулд үйлдвэрлэлийн бодит ахиу зардлыг тодорхойлох хүчин зүйлсийн судалгааг хийх хэрэгцээг Волман 1999 оны судалгааны ажлаараа дэвшүүлсэн (Wolman 1999).

Үйлдвэрлэлийн ахиу зардал болон ажиллагчдын хамаарал

Үйлдвэрлэлийн бодит ахиу зардлын талаар олон төрлийн эмпирик судалгааны ажлууд хийгдсэн байдгийн дотор Японы төв банкны судлаачийн “Бодит ахиу зардлыг сайжруулан Шинэ Кейнсийн Филипсийн муруйг үнэлэх нь: Япон улс” судалгааны ажлыг тус шинжилгээний суурь үндэслэл болгон ашиглав. Уг судалгаанд хөдөлмөрийн зах зээлийн хөшүүн байдлыг (i) хөдөлмөр тохируулгын зардал болон (ii) бодит цалингийн хөшүүн байдлаар төлөөлүүлэн, хөдөлмөр тохируулгын зардлыг ажиллагчдын тооны өөрчлөлтөөр авч үзсэн (Muto 2007) байдаг.

Үйлдвэрлэлийн бодит ахиу зардал болон хөдөлмөрийн тооны өөрчлөлтийн хамаарал нь онолын болон эмпирик шинжилгээний үндэслэлтэй тул шинжилгээнд ОУВС-гийн эдийн засагчдын боловсруулсан “Мөнгөний бодлогын шинжилгээний GAP загвар”-аас үнэлэгдэн гарсан үйлдвэрлэлийн бодит ахиу зардал (бодит ханшийн зөрүү болон гарцын зөрүүгээр тооцогдсон) болон ажиллагчдын тооны хамаарлыг шинжлэн үзэв. Уг шинжилгээ нь цаашид үйлдвэрлэлийн бодит ахиу зардлын бүтцийг дэлгэрүүлэх, инфляц болон хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан макро эдийн засгийн төлөв байдлыг нарийн тодорхойлох суурь болох, мөн хөдөлмөрөөс илүү, капиталд түшиглэсэн бөгөөд үйлдвэрлэлийн хэмжээ нь импорт, бодит ханшаас хамааралтай салбаруудыг тодорхойлох боломжийг олгох юм.

Шинжилгээний үр дүн

Үйлдвэрлэлийн ахиу зардал нь бүтээгдэхүүн, үйлчилгээнд шаардагдах дотоодын болон импортын бүтээгдэхүүний зардлын өөрчлөлтийг илэрхийлэх хувьсагч юм. Манай улсын хувьд уг зардлын өсөлт нь ажиллагчдын тооны өсөлттэй хүчтэй сөрөг буюу -64 хувийн шугаман хамааралтай байна (2019 оны 1 дүгээр улирлаас 2024 оны 1 дүгээр улирал хүртэлх хугацаагаар тооцов). Мөн уг хамаарлын детерминацын коэффициентыг тооцон үзэхэд үйлдвэрлэлийн зардлын өсөлт нь ажиллагчдын тооны өөрчлөлтийг 41 хувийн магадлалтай тайлбарлах чадвартайг илэрхийлж байна.

Дээрх үр дүнд тулгуурлан эдийн засгийн үйл ажиллагааны салбар тус бүрээр үйлдвэрлэлийн зардал, ажиллагчдын тооны хамаарлыг авч үзэх нь хөдөлмөрийн зах зээлийн цаашдын төлөв байдлыг (салбаруудын ажиллагчдын хөдөлгөөн) макро эдийн засгийн төлөв байдлаас (бодит ханшийн зөрүү, үйлдвэрлэлийн зөрүү) хамааруулан хүлээлт тодорхойлох боломжийг олгох юм.

Тус корреляцийн шинжилгээний үр дүнгээр ажиллагчдын тоо хэмжээ нь үйлдвэрлэлийн зардлын өөрчлөлт, тэр дундаа бодит ханшийн өөрчлөлтөд харьцангуй мэдрэг салбаруудад барилга, тээвэр, уул уурхай, боловсруулах, зочид буудал, нийтийн хоол, мэдээлэл холбоо, боловсролын салбарууд багтаж байна. Эдгээр салбаруудад нийт ажиллагчдын 35 гаруй хувь нь ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, нийт ажиллагчдын 35 хувийг бүрдүүлж буй дээрх салбаруудын ажиллагчид (хүмүүн капиталын орц)-ын тоо хэмжээнд ханшийн өөрчлөлт харьцангуй өндөр нөлөөтэй юм.


Зураг 1.8. Үйлдвэрлэлийн бодит зардал болон ажиллагчдын хамаарал

1. Үйлдвэрлэлийн бодит ахиу зардлын өсөлт болон ажиллагчдын хөдөлгөөн (сая хүн: баруун тэнхлэг, хувь: зүүн тэнхлэг)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол
Тэмдэглэл: Үйлдвэрлэлийн бодит ахиу зардлыг Мөнгөний бодлогын шинжилгээний GAP загвараас тооцов.

2. Үйлдвэрлэлийн зардлын өсөлт болон ажиллагчдын тооны корреляцийн коэффициент (-1 утгаас 1 хооронд)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол
Тэмдэглэл: Корреляцийн коэффициентийг 2019 оны нэгдүгээр улирлаас тайлант улирал хүртэлх хугацаагаар тооцов.

3. Үйлдвэрлэлийн зардал болон ажиллагчдын өөрчлөлтийн цэгэн тархалт (хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

БҮЛЭГ II

ТӨСВИЙН СЕКТОР

- 2.1 ТӨСВИЙН БОДЛОГО
- 2.2 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН
ТОГВОРТОЙ БАЙДАЛ

II. ТӨСВИЙН СЕКТОР

ТОЙМ

Эдийн засгийн идэвхжил төсвийн орлогод эергээр нөлөөлж, төсөв 2024 оны эхний улирлын байдлаар 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарсан нь төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг дунд хугацаанд үе шаттайгаар бууруулах бодлогын зорилтыг хангалаа. Төсвийн зарлага өрхийн орлогыг хамгаалж, иргэдийн нийгмийн баталгааг сайжруулахад чиглэж байна. Түүнчлэн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2024 оны эхний улирлын байдлаар 33.7 хувьд хүрч буурсан нь 50 хувиас бага түвшинд хадгалах зорилттой нийцтэй байна.

Цаашид төсвийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх хүрээнд Засгийн газрын өрийн менежментийг оновчтой хэрэгжүүлж, хуримтлалын тогтолцоог сайжруулан төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй.

ТӨСВИЙН БОДЛОГО


23. Дотоод эрэлт сайжирч, уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдсэн эерэг нөлөөгөөр төсвийн тэнцэл ашигтай гарлаа. Нэгдсэн төсөв 2024 оны эхний улиралд 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 970 тэрбум төгрөг буюу 47.7 хувиар нэмэгдсэн байна. Төсвийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 51.3 хувиар нэмэгдсэн нь төсөв ашигтай гарахад голлон нөлөөллөө.

24. Эдийн засгийн идэвхжил төсвийн орлогын бүрдүүлэлтэд эергээр нөлөөллөө. Нэгдсэн төсвийн нийт орлого 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр 7,673 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөний биелэлт 98.1 хувийн гүйцэтгэлтэй байв. Эдийн засгийн идэвхжил, өрхийн бодит орлого, иргэдийн худалдан авалт өсөж, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа хэвийн явагдсанаар татварын орлого өмнөх оны мөн үеэс 2.4 их наяд төгрөг буюу 52.3 хувиар өссөн нь төсвийн орлогын өсөлтийн голлох шалтгаан боллоо. Бүтцээр нь авч үзвэл ХХОАТ 165 тэрбум төгрөгөөр буюу 44.7 хувиар, ААНОАТ 985 тэрбум төгрөг буюу

88.3 хувиар өссөн байна. Түүнчлэн, эрдэс баялгийн экспортын биет хэмжээ өссөнтэй холбоотойгоор АМНАТ-өөс төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 533 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 1.1 их наяд төгрөгт хүрлээ. Төсвийн нийт орлого 2024 онд 27.7 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого 2024 онд 25.9 их наяд төгрөг байхаар батлагдсан.

25. Төсвийн зарлага өрхийн орлогыг хамгаалж, иргэдийн нийгмийн баталгааг сайжруулахад чиглэж байна. Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх, бодит орлогыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд хүүхдийн мөнгийг хүүхэд бүрд олгох, 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс цалин, тэтгэвэр нэмэгдүүлэх, болон бусад холбогдох шийдвэрүүдийг гаргасан. 2024 оны эхний улирлын байдлаар цалингийн зардал өнгөрсөн оны мөн үеэс 624 тэрбум төгрөг буюу 2.4 дахин, тэтгэмжийн зардал өнгөрсөн оны мөн үеэс 235 тэрбум төгрөг буюу 26.4 хувиар тус тус нэмэгдсэн байна. Монгол Улсын 2024 оны төсвийн нийт урсгал


Зураг II.1. Төсвийн орлого, зарлага, тэнцэл



зардал 21.2 их наяд төгрөг байхаар батлагдсан ба үүний 35.9 хувь нь төрөөс иргэдэд олгодог нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмж, 25.3 хувь нь төрийн албан хаагчдад олгох цалин хөлс, 11.7 хувь нь төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой урсгал зардал, 7.3 хувь нь

хүүхдийн мөнгөн тэтгэмж, 2.9 хувь нь төрөөс иргэн, аж ахуйн нэгжид олгох хөнгөлөлт, чөлөөлөлт, 5.5 хувь нь гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр, 1.6 хувь нь гүйцэтгэлээр санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын урсгал зардал байна.

Зураг II.2. Төсвийн төлөв тэнцэл, автомат тогтворжуулагч




26. Төсвийн хумих бодлого хэрэгжиж байна.

Эдийн засгийн мөчлөгийн нөлөөг арилгасан үндсэн тэнцэл 2.2 их наядын ашигтай гарсан нь төсвийн хумих бодлого хэрэгжиж байгааг харуулж байна. Зураг II.2-т төсвийн нийт алдагдлын хэмжээнд үзүүлж буй төсвийн бодлогын нөлөөг төсвийн төлөвөөр, төсвийн бодлогоос хамаарахгүй эдийн засгийн мөчлөгийн өөрийн нөлөөг төсвийн автомат тогтворжуулагчаар⁷, өрийн дарамтын нөлөөг хүүгийн зардлаар илэрхийлэн харууллаа. Төсвийн тэнцэлд үзүүлэх хүүгийн зардлын нөлөө ДНБ-ий 0.9 хувь буюу 154 тэрбум төгрөг, автомат тогтворжуулагч буюу эдийн засгийн мөчлөгийн нөлөө 0.23 хувь буюу 38.6 тэрбум төгрөг, төсвийн төлөвийн бодлогоос шалтгаалсан нөлөө -13.19 хувь буюу -2171 тэрбум төгрөг байна. Эдийн засгийн мөчлөгөөс шалтгаалсан буюу төсвийн бодлогоос үл хамаарах төсвийн тэнцлийн хэлбэлзлийг илэрхийлэх автомат тогтворжуулагч 2024 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 65.4 тэрбум төгрөгөөр өссөн нь төсвийн бодлогоос бус эдийн засгийн идэвхжилтэй холбоотой орлогын эерэг өөрчлөлт тус хэмжээнд байсныг илтгэж байна.

27. ОУВС-гийн тооцооллоор 2024 онд дэлхийн улс орнуудын төсвийн үндсэн тэнцэл ашигтай гарч, төсвийн хумих бодлого хэрэгжих хүлээлттэй байна (Зураг II.3). Тус сангаас дэлхийн улс орнуудын 71 хувь нь энэ онд төсвийн хумих бодлого хэрэгжүүлнэ гэж тооцоолсон байна.

Зураг II.3. Дэлхийн улс орнуудын мөнгөний болон төсвийн бодлого (эзлэх хувь)



Эх сурвалж: ОУВС, Төсвийн хяналт (Fiscal Monitor) тайлан
Тайлбар: Дээрх үзүүлэлтийг тооцохдоо хөгжингүй 34, хөгжиж буй 20 улсаар тооцсон. Мөчлөгийн нөлөө арилгасан үндсэн тэнцэл эерэг (сөрөг) бол төсвийн хумих (тэлэх) бодлого хэрэгжиж байна гэж үзэх бол Төв банкнаас тогтоох бодлогын хүү нэмэгдсэн (буурсан) бол мөнгөний хатуу (зөөлөн) бодлого хэрэгжүүлсэн гэж үзнэ.

⁷ Эдийн засгийн тэлэлт буюу сэргэлтийн үед эдийн засгийн үйл ажиллагаа эрчимжихийн хэрээр төсвийн орлого нэмэгдэж, эсрэгээрээ эдийн засгийн агшилт буюу уналтын үед татварын орлого буурч, ажилгүйдэл өссөнөөр ажилгүйдлийн тэтгэмж гэх мэт төсвийн зардал нэмэгддэг. Ийнхүү засгийн газрын төсвийн бодлогоос үл хамааран төсвийн тэнцэл өөрчлөгдөж, эдийн засгийг тогтворжуулах чиглэлд ажиллаж байгааг төсвийн тэнцлийн автомат тогтворжуулагч гэнэ.


ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

28. Засгийн газрын өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар буурч, сүүлийн 7 улирлын хамгийн бага дүнд хүрлээ. Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл 2024 оны эхний улирлын эцэст 29.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.6 их наяд төгрөгөөр буурсан байна. Засгийн газрын өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 33.7 хувьд хүрсэн нь 2023 оны эцсээс 4.9 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Засгийн газрын өр буурахад гадаад өр 5.3 хувиар, дотоод өр 1.9 хувиар, болзошгүй өр төлбөр 2.2 хувиар тус тус буурсан нь зэрэг нөлөө үзүүлэв. Тухайлбал, Засгийн газрын гадаад өр 2023 оны эцсээс 732 тэрбум төгрөгөөр буюу 2.4 хувиар, дотоод өр 37.5 тэрбум төгрөгөөр буюу 16 хувиар тус тус буурсан байна. Түүнчлэн 2024 оны эхний улирлын байдлаар Засгийн газрын барих-шилжүүлэх төрлийн концессын өр төлбөрийн үлдэгдэл болох 236.5 тэрбум төгрөгийг бүрэн барагдуулсан байна.

29. Гадаад бондын төлбөрийг хугацаанд нь барагдуулсан нь Засгийн газрын нийт өр буурахад голлох нөлөө үзүүлээ. Олон улсын зах зээлд гаргасан бондын төлбөр 439 тэрбум, гадаад зээл 63 тэрбумаар тус тус буурснаар Засгийн газрын гадаад өр өмнөх оны эцсээс 3.3 хувиар буурлаа. Өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд санхүүжилтийн тодорхой хэсгийг шийдээд байсан Хуралдай бондын үлдэгдэл 53 сая ам.долларын төлбөрийг 2024 оны 3 дугаар сард бүрэн барагдуулсан нь Засгийн газрын гадаад үнэт цаасны өр буурахад голлон нөлөөллөө. Улсын төсвөөс Засгийн газрын үнэт цаасны төлбөрт 204 тэрбум төгрөг, гадаад зээл төлбөрт 196 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Эргэн төлөлт хүлээгдэж буй Номад, Сенчири-1, Сенчири-2, Сенчири-3 бондууд бүгд өрийн дахин санхүүжилтийн зорилгоор олон улсын зах зээлд гаргасан бондууд байна. Түүнчлэн энэ оны эхний улирлын байдлаарх Засгийн газрын гадаад өр Монгол Улсын нийт гадаад өрийн 22.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.8 нэгж хувиар бага дүн юм.

30. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа бусад улсын дунджаас доогуур байна. Засгийн газрын гадаад валютаар илэрхийлсэн өрийн нэрлэсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа хөгжиж буй улсуудын дунджаас доогуур түвшинд хүрээд байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 2019 онд 68.1 хувь, хөгжиж буй орнуудын хувьд 55 хувь байсан бол 2023 оны байдлаар хөгжиж буй орнуудын дундаж 68 хувьд, Монгол Улсын Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 51.9 хувьтай тэнцэх хэмжээнд хүрээд байна. Дээрх үзүүлэлт хөгжингүй улсуудын хувьд өндөр байх зүй тогтол ажиглагдаж байгаа бол хөгжиж буй, бага дунд орлоготой орнуудын хувьд доогуур түвшинд байх хандлагатай байна. Дэлхийн нийт улсуудын Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 2023 оны байдлаар 93.3 байгаа бол ОУВС-ын шалгуураар бага орлоготой орнуудын хувьд 53.2 хувь байна.

Зураг II.4. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл (нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, ОУВС
Тайлбар: Дээрх үзүүлэлт нь Засгийн газрын гадаад валютаар илэрхийлсэн өрийн нэрлэсэн үлдэгдлийг ам.доллараар илэрхийлэгдсэн нэрлэсэн ДНБ-д жинлэн тооцсон дүн болно.
*2024 оны үзүүлэлт нь Монгол Улсын хувьд ЗГ-ын 2024 оны эхний улирлын өрийг үлдэгдлийг ЭЗХЯ-ны 2024 оны ДНБ-ий төсөөлөлд харьцуулан тооцсон, бусад орнуудын хувьд ОУВС-гийн төсөөлөлд үндэслэн тооцсон болно.

ШИГТГЭЭ 4. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталлаа. Тус хуулийг боловсруулахдаа макро эдийн засгийг тогтворжуулах үндсэн чиглэлийг баримтлан боловсруулсан бөгөөд дараах голлох зорилтуудыг тусгасан. Үүнд:

- Эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд 6-аас дээш хувьд тогтвортой хадгална.
- Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах, өрхүүдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд инфляцыг бууруулж, 2025 онд 6 хувь, 2026 онд 4 хувь, 2027 онд 3 орчим хувьд хүргэнэ.
- Экспортын орлогыг нэмэгдүүлж, гадаад валютын улсын нөөцийг 2026 онд 10 тэрбум ам.долларт хүргэнэ.
- Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг 2025 онд -2.0 хувь, 2026 онд -1.5 хувь, 2027 онд -1.0 хувь болгон бууруулж, цаашид төсвийг алдагдалгүй бодлого баримтална.
- Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн засгийн газрын өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг үе шаттайгаар бууруулан 2025 онд 50 хувь, 2026 онд 45 хувь, 2027 онд 40.0 хувьд хязгаарлана.

Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон бусад холбогдох хуулиудад заасан төсвийн тусгай шаардлагуудад бүрэн нийцүүлж, төр, хувийн хэвшил, олон улсын байгууллага, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, иргэдийн холбогдох саналыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан.

Хүснэгт II.1 Монгол улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөл

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2025 он	2026 он	2027 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	8.0	6.5	6.5
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.0	4.0	3.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	29,400.1	31,951.2	34,460.3
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	30.9	30.5	29.5
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	31,300.4	33,521.8	35,628.1
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.9	32.0	30.5
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	3,939.9	2,221.4	2,106.3
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	4.1	2.1	1.8
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,900.3	-1,570.6	-1,167.8
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.0	-1.5	-1.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	7,273.3	7,564.2	7,866.8
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	7.7	7.2	6.7
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	47,507.1	47,117.6	46,708.6
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	50.0	45.0	40.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,850.4	2,931.8	3,269.6
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.0	2.8	2.8

БҮЛЭГ III

МӨНГӨНИЙ СЕКТОР

- 3.1 ИНФЛЯЦ, МӨНГӨНИЙ БОДЛОГО
- 3.2 САНХҮҮГИЙН САЛБАР

III. МӨНГӨНИЙ СЕКТОР

ТОЙМ

Импортын болон дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт саарснаар инфляц 2024 оны эхний улиралд 7.0 хувь болж, төв банкны зорилтот түвшинд хадгалагдав. Төв банк 2024 оны эхний улиралд мөнгөний бодлогын хүүг 15 сарын дараа анх удаа бууруулж, мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлж эхэллээ. Инфляцын түвшин буурч бодит хүү нэмэгдсэн, төгрөгийн ханш тогтвортой байгаа нь өрхийн бодит орлогыг нэмэгдүүлж, нийт хадгаламжийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ. Арилжааны банкнуудын зээлийн эх үүсвэр нэмэгдсэнээр, иргэд, аж ахуй нэгжид шинээр олгосон зээлийн хэмжээ нэмэгдсэн байна. Мөн арилжааны банкнуудын чанаргүй зээл буурч, өөрийн хөрөнгийн хүрэлцээ нэмэгдсэнээр ашигт ажиллагааны үзүүлэлтүүд сайжирлаа.

Цаашид инфляцыг бууруулах чиглэлд хөдөө аж ахуйн салбарт цогц шинэчлэл хийж хүнсний нийлүүлэлтийг сайжруулах, экспорт, импортын тээврийн зохицуулалтыг оновчтой хийж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, төсвийн алдагдлыг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ИНФЛЯЦ БА МӨНГӨНИЙ БОДЛОГО

31. 2024 оны эхний улиралд инфляцын түвшин төсөөлөлтэй нийцтэйгээр буурч, төв банкны зорилтот түвшинд хадгалагдлаа. Дундаж инфляц 2024 оны эхний улиралд 7.2 хувь болж, өмнөх оны мөн үеийн дундаж 12.2 хувьтай харьцуулахад 5 нэгж хувиар буурлаа.


32. Жилийн инфляц 7.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 5.2 нэгж хувиар буурлаа. Инфляцын бууралтын 1.9 нэгж хувийг хүнсний бараа, согтууруулах бус ундаа, 0.8 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутал, 0.9 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, 0.4 нэгж хувийг гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа, 1 нэгж хувийг тээвэр тус тус бүрдүүлсэн байна.

33. Нийт инфляцын 4.1 нэгж хувийг эдийн засгийн сэргэлттэй холбоотой эрэлтийн гаралтай инфляц, 2.9 нэгж хувийг тус нийлүүлэлтийн гаралтай инфляц бүрдүүлэв. Тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин нэмэгдэн өрхийн хэрэглээ өсөж, дотоод эрэлт идэвхэжсэнтэй холбоотойгоор эрэлтийн инфляц нь нийт инфляцын дийлэнх буюу 60 орчим хувийг бүрдүүллээ.

34. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад импортын инфляц 2.8 нэгж хувиар, дотоодын бараа, үйлчилгээний инфляц 2.4 нэгж хувиар тус тус буурлаа. Хэрэглээний сагсны нийт 410 барааны 220 буюу 46 хувийг импортын бараа, бүтээгдэхүүн, 190 буюу 54 хувийг дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрдүүлдэг. Импортын барааны үнийн өсөлт 2024 оны эхний улиралд нийт инфляцын 34.1 хувийг бүрдүүллээ. Импортын инфляц буурахад төгрөгийн ханш тогтворжсон, гадаад үнэ болон тээвэр, логистикийн саатал арилсан зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлөв. Дотоодын бараа, үйлчилгээний инфляц буурахад хүнсний бараа, согтууруулах бус ундаа 1.9 нэгж хувиар, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 0.3 нэгж хувиар буурсан нь голлох нөлөө үзүүллээ.

35. Нийт инфляцын 2.8 нэгж хувь нь хүнсний инфляц, 4.2 нэгж хувь нь хүнсний бус инфляц байв. Хүнсний бүлгийн үнэ 2024 оны эхний улиралд жилийн 9.8 хувийн өсөлттэй гарч, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн инфляц өндөр хэвээр байна. Хүнсний бүлгийн үнийн өсөлтөд гурил, гурилан

Зураг III.1. Инфляцын бүрэлдэхүүн



бүтээгдэхүүний үнэ 17.4 хувиар, мах, махан бүтээгдэхүүний үнэ 10.9 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ 10.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Эдгээр бүтээгдэхүүний үнийн өсөлт хүнсний инфляцын 60 орчим хувийг тайлбарлаж байна.

36. Улаанбаатар хотын инфляц өмнөх оны мөн үеэс 5.1 нэгж хувиар буурч, 7 хувьд хүрэв. Үүнд дийлэнх бараа, үйлчилгээний бүлгүүдийн үнийн өсөлт саарсан нь нөлөөлжээ. Улаанбаатар хотын хүнсний бүлгийн инфляц өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.3 нэгж хувиар буурч, 9.3 хувь болсон болон тээврийн бүлэг 0.6 хувийн дефляцитай гарсан нь хотын инфляц буурахад гол нөлөө үзүүлсэн байна. Тээврийн бүлгийн инфляц буурахад АИ-92 шатахууны үнэ сүүлийн нэг жилийн хугацаанд тогтвортой байсан, АИ-80 шатахууны үнэ өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буурсан, дизель түлшний үнэ 6.8 хувиар буурсан нь нөлөөлжээ. Харин 2023 оны намар боловсролын үйлчилгээний үнэ 21.2 хувиар өссөн нөлөөгөөр уг бүлгийн хотын инфляц 0.5 нэгж хувиар өсжээ.


37. Олон улсад чингэлэг тээврийн үнэ болон хүнсний үнийн индекс сүүлийн сар өссөн нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ бизнесүүд бэлтгэл ажлаа өмнөх жилүүдтэй харьцуулахад эрт эхэлсэн болон Улаан тэнгис дэх Суэцийн сувагт үүсээд буй халдлагын нөлөөгөөр өмнөх оны мөн үеэс 202 хувиар өсөж 40 фут чингэлэг тутамд 4,801 ам.долларт хүрээд байна. Энэ нь Ковид-19 цар тахлын өмнөх үеийн дунджаас 187 хувиар өндөр үзүүлэлт юм. 2024 оны 5 дугаар сард хүнсний үнийн индекс өмнөх сараас бага зэрэг өссөн боловч өмнөх оны мөн үетэй харьцуулахад

3.4 хувиар буурчээ. Дэлхийн зах зээл дээр үр тариа, сүүн бүтээгдэхүүний үнэ буурсан бол ургамлын тос болон үр тарианы үнэ бага зэрэг өсөж, махны үнэ өөрчлөгдөөгүй байна. Манай улсын худалдааны түнш ихэнх орнуудын инфляц буурч байна. Тухайлбал, Евро бүс, Америк, Их Британи, Япон, Солонгос, Шри-Ланк, Казахстан, Киргизстан улсуудын жилийн инфляц сүүлийн сар буурсан бол Орос, Хятад, Гүрж, Турк, улсуудын инфляц сүүлийн сар өсжээ.

38. Мөнгөний бодлогын хүү эдийн засгийн төлөв байдалтай нийцэж зохистой түвшинд байна. Төв банкнаас 2024 он гарснаас хойш бодлогын хүүг 2 удаа нийт 2 нэгж хувиар бууруулж, 11 хувь болгох шийдвэр гаргасан. 2024 оны эхний улирлын байдлаар бодлогын хүүгийн зохистой утгыг илэрхийлэх Тэйлорын дүрмээр тооцсон хүү 12.3 хувь байгаа нь төв банкны нэгдүгээр улирлын бодлогын хүү 12.7 хувийн орчимд байв. Цаашид, банкнуудын шинээр олгох зээлийн өсөлт хадгалагдахын зэрэгцээ тээвэр логистикийн саатлаас үүдэлтэйгээр импортын барааны үнэ өсөх эрсдэл ажиглагдаж байгаа тул бодлогын хүүг богино хугацаанд дахин бууруулахгүй байх нь тохиромжтой байна.

39. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн 3 улирлын турш богино хугацааны зорилтот түвшнээс их байна. 2024 оны эхний улиралд мөнгөн хөрөнгийн илүүдэл (money overhang) тооцооллоор 3.4 хувьд хүрсэн нь мөнгөний богино хугацааны зорилтот өсөлт нь урт хугацааны зорилтот өсөлтөөс их байгааг илтгэж байна. Мөнгөн хөрөнгийн илүүдэл өмнөх улирлаас буурсан боловч сүүлийн 2 улиралд эерэг байгаа нь мөнгөний нийлүүлэлт тэнцвэрт түвшнээс өндөр байгааг илэрхийлж байна.

Зураг III.2. Тэйлорын хүү, мөнгөний зорилтот өсөлт, мөнгөний илүүдэл




САНХҮҮГИЙН САЛБАР

40. Төлбөрийн тэнцэл сайжирсантай холбоотой банкны системийн гадаад цэвэр актив нэмэгдсэнээр мөнгөний нийлүүлэлт өсөлттэй байлаа. Мөнгөний нийлүүлэлт 2024 оны эхний улирлын эцсийн байдлаар 37.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 20.9 хувиар өслөө. Үүнээс, төгрөгийн хадгаламж 16.3 нэгж хувь, төгрөгийн харилцах 9.5 нэгж хувь, гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 0.2 нэгж хувиар өссөн бол валютын хадгаламж 4.7 нэгж хувь, валютын харилцах 0.4 нэгж хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Төлбөрийн тэнцэл сайжирсантай холбоотой банкны системийн гадаад цэвэр актив, зээл олголтын хэмжээ өсөлттэй байсан зэрэг нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд эергээр нөлөөлөө.

41. Арилжааны банкнуудын зээлийн жилийн өсөлтийн хурд өслөө. Арилжааны банкнуудаас олгосон нийт зээлийн үлдэгдэл 2024 оны эхний улирлын байдлаар 28.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.7 хувиар өслөө. Банкнууд 2024 оны эхний улиралд автомашин, хэрэглээний зээлийн шалгуураа бага зэрэг сулруулж, бусад зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй бөгөөд өрхийн хэрэглээний зээлийн өрийн үлдэгдэл 374.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.2 дахин өссөн байна. Үүнээс, цалингийн зээл 4.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 43.1 хувь, тэтгэврийн зээлийн өрийн үлдэгдэл 1.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 57.7 хувь, малчны зээл 1.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар тус тус өслөө.

Зураг III.3 Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд




42. Эдийн засаг идэвхжиж шинээр олгосон зээл өмнөх оны мөн үеэс өслөө. Шинээр олгосон зээлийн хэмжээ 2024 оны эхний улиралд 11.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 36.9 хувиар буюу 3.1 их наяд төгрөгөөр өссөн байна. Шинээр олгосон зээлийн өсөлтийг салбараар харвал худалдааны салбарын зээл 13.1 нэгж хувь, цалингийн зээл 5.5 нэгж хувь, хадгаламж барьцаалсан зээл 4.3 нэгж хувь, санхүү даатгалын салбарын зээл 3.8 нэгж хувь, уул уурхайн салбарын зээл 2.2 нэгж хувийг гэх мэтчилэн бүрдүүлж байна.

43. Чанаргүй зээлийн нийт өрийн үлдэгдэлд эзлэх хувь буурч байна. Банкнуудын чанаргүй зээлийн нийт хэмжээ 2024 оны эхний улиралд 2.1 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь нийт зээлийн үлдэгдлийн 7.1 хувийг эзэлж байна. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оноос 167.0 тэрбум төгрөгөөр, нийт зээлийн өрийн хэмжээнд эзлэх хувь хэмжээгээр өмнөх оны мөн үеэс 2.5 нэгж хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Чанаргүй зээлийн бууралт нь эдийн засгийн өсөлт, санхүүгийн салбарын тогтвортой байдалд эергээр нөлөөлөхийн зэрэгцээ зээлийн хүү буурах, бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг мөнгө, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах чухал ач холбогдолтой.

44. Инфляцын түвшин буурч, бодит хүү нэмэгдэж, төгрөгийн ханш тогтвортой байгаа нь өрхийн бодит орлогыг нэмэгдүүлж, нийт хадгаламжийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ. Банкны хадгаламжийн жилийн өсөлт 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 18.9 хувиар өсөж, 22.4 их наяд төгрөгт хүрлээ. Нийт хадгаламжид иргэдийн хадгаламж 83 хувь, байгууллагын хадгаламж 17 хувийг тус тус бүрдүүлж байна. Хадгаламжийн өсөлт, хадгаламжийн хүү нийлүүлэлт талаасаа эерэг хамааралтай байдаг. Хадгаламжийн хүү 2024 оны эхний улиралд 11.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар өсөж, үнийн түвшин харьцангуй тогтвортой байгаа нь хадгаламжийн нийт өсөлтөд гол нөлөө үзүүлээ.

45. Хадгаламж, зээлийн хүүгийн зөрүү өмнөх оны мөн үеэс буурч байна. Арилжааны банкнуудын зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өсөж, 17.0 хувьтай байх хугацаанд зээл олголтын хэмжээ нэмэгдсэн нь банкнуудын ашигт ажиллагааг сайжруулсан байна. Богино хугацаанд хадгаламж, зээлийн хүүгийн зөрүү буурах нь эдийн засгийн идэвхжилийг өдөөж өгдөг сайн талтай.

Зураг III.4 Зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд




Зураг Зураг III.5 Нийт хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн түвшин



46. Банкнүүдэн ашигт ажиллагаанд чанаргүй зээлийн хэмжээ буурсантай холбоотой активын чанар сайжирсан нь эерэг нөлөө үзүүлээ. Банкнүүдэн активын өгөөж 2024 оны эхний улиралд 2022 оны 4 дүгээр улирлаас хойш 6 улирлын дунджаар 2.45 хувьд хүрч, 2020 оны дунджаас 3.6 дахин, 2021 оны дунджаас 1.8 дахин өссөн байна. Банкнүүдэн хувьд ашигт ажиллагаа нь чанаргүй зээлийн түвшинтэй нягт урвуу хамааралтай байна. Чанаргүй зээл буурч хэвийн зээл олголт өссөнтэй холбоотойгоор хүүгийн орлого нэмэгдсэн эерэг нөлөө үзүүлсэн байна.

47. Арилжааны банкнүүдэн өөрийн хөрөнгийн өсөлт нэмэгдэж, валютын ханшийн эрсдэл буурлаа. Банкны тухай хуульд 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани, бусад банк нь хувьцаат компанийн хэлбэртэй байхаар нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу хуулийн хэрэгжилтийн хүрээнд томоохон банкнүүд анхдагч зах зээлээс хөрөнгө татсан. Арилжааны банкнүүдэн өөрийн хөрөнгийн өсөлт 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеийн жилийн өсөлтөөс 12.1 нэгж хувиар өсөж, 28.6 хувийн өсөлтөд хүрлээ. Цэвэр нээлттэй позиц

Зураг III.6. Арилжааны банкнүүдэн ашигт ажиллагаа ба зохистой харьцааны үзүүлэлт




нийт өөрийн хөрөнгийн харьцаа тус хугацаанд өмнөх оны мөн үеэс абсолют утгаар 4.6 нэгж хувиар буурсан нь банкнуудын валютын ханшийн эрсдэл буурсан байна.

48. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үеэс өслөө. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2024 оны эхний улиралд 11.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.8 дахин өслөө. Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ дотоодын нийт бүтээгдэхүүний 17.5 хувьтай тэнцэж байгаа бөгөөд банкнуудын анхдагч зах зээлд хувьцаа арилжаалж эхэлсэнтэй холбоотой сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон арилжааны идэвх сайжирч байна. Нийт үнэт цаасны арилжаа 2024 оны эхний улиралд 204.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.4 дахин нэмэгдсэн бөгөөд арилжааг төрлөөр нь харвал 67.8 хувийг хувьцааны арилжаа, 22.6 хувийг компанийн бондын арилжаа, 8.9 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа, 1.2 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус бүрдүүлсэн байна.

49. Үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар сайжирч, TOP-20, MSE-A индексийн үзүүлэлт өслөө. Хөрөнгийн зах зээл дээр 2024 оны эхний улиралд нийт 62 удаагийн арилжаагаар 124 хувьцаат компанийн 127.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааны арилжаа хийгдсэн бөгөөд 7.0 хувь буюу 8.9 тэрбум төгрөгийг анхдагч зах зээлийн арилжаа, 93.0 хувь буюу 118.7 тэрбум төгрөгийн гүйлгээг хоёрдогч зах зээлийн арилжаа эзэлж байна. Мөн компанийн өрийн хэрэгслийн арилжаа 42.6 тэрбум төгрөг болж өмнөх мөн үеэс 3.6 дахин буюу 30.9 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд компанийн шинээр гаргасан бондын арилжаа бүртгэгдээгүй байна. Тайлант хугацаанд ТОП-20 индексийн үзүүлэлт 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.7 хувиар өссөн байна. Үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадварын харьцаа өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар нэмэгдэж, 1.0 хувь болж өслөө.

Зураг III.7. Хөрөнгийн зах зээл



БҮЛЭГ IV

ГАДААД СЕКТОР

- 4.1 ГАДААД ХУДАЛДАА
- 4.2 ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ
- 4.3 ГАДААД ӨР

IV. ГАДААД СЕКТОР

ТОЙМ

Гадаад худалдааны бараа эргэлт 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өслөө. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн ч нүүрсний экспортын үнэ буурч, өвөлжилт, хаваржилтын хүндрэл хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортод сөргөөр нөлөөлснөөр нийт экспортын орлого өмнөх оны мөн үеэс бага зэрэг буурлаа. Харин дотоод эдийн засгийн идэвхжил хадгалагдаж, өрхийн орлого, арилжааны банкнуудын зээл олголт нэмэгдэж, иргэд, аж ахуй нэгжийн худалдан авах чадвар сайжирсан нь импортын өсөлтийг өдөөж, гадаад худалдааны бараа эргэлт нэмэгдэхэд голлон нөлөөлөө. Импортын өсөлтөөс шалтгаалан урсгал данс алдагдалтай гарсан ч шууд хөрөнгө оруулалт, зээлийн орох урсгал нэмэгдсэнээр төлбөрийн тэнцэл өмнөх оны мөн үеэс сайжирч, гадаад валютын нөөц нэмэгдэж, төгрөгийн ханш чангарлаа.

Цаашид экспортын хэмжээ, бүтээгдэхүүний төрөл, боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, валютын нөөцийг нэмэгдүүлж, импортын гаралтай инфляцын дарамтыг бууруулах, гадаад өрийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх зэрэг валютын ханшийн тогтвортой байдал, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

50. Гадаад худалдааны бараа эргэлт нэмэгдэж, худалдааны тэнцэл ашигтай гарлаа. Гадаад худалдааны бараа эргэлт 2024 оны эхний улиралд 6.1 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өслөө. Экспортын орлого өмнөх оны мөн үеэс 2 хувиар буурсан ч гадаад худалдааны тэнцэл 1.2 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

51. Экспортын орлогын гүйцэтгэл төсөөллөөс бага түвшинд гарлаа. 2024 оны эхний улиралд нийт экспорт 3.7 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2 хувиар буурч, төсөөллөөс бага түвшинд гарлаа. Экспортын голлох түүхий эдийн үнэ буурсан, малын зүй бус хорогдол өндөр байсан зэрэг нь экспортын орлого буурахад голлох нөлөө үзүүлээ.

52. Гадаад эрэлт сайн байж, нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдсэн ч Ганцмод боомт дахь коксжих нүүрсний үнэ буурснаар нүүрсний экспортын орлого буурлаа. Уурхайн хяналт шалгалтын улмаас БНХАУ-ын коксжих нүүрсний дотоод үйлдвэрлэл 2024 оны эхний улиралд өнгөрсөн оны мөн үеэс 12 хувиар буурсан байна. Үүнээс шалтгаалж тус улсын коксжих нүүрсний импорт нэмэгдсэн нь манай улсын коксжих нүүрсний экспортыг тэтгэж, Монгол Улс 2024 оны эхний улиралд 17.7 сая тонн нүүрс экспортолж, нүүрсний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 28 хувиар нэмэгдлээ. Гэсэн хэдий ч Ганцмод боомт дахь Монгол Улсын коксжих нүүрсний дундаж үнэ 1,490 юань болж, өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар буурсан байна.

53. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалж буй нүүрсний хэлцлийн үнэ нь биржийн бус зах зээл дэх хилийн үнээс өндрөөр тогтож байна. 2024 оны эхний улирлын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 5.2 сая тонн нүүрсийг 135 ам долларын дундаж үнээр арилжаалсан нь биржийн бус худалдааны хилийн дундаж үнээс

7 хувиар өндрөөр тогтож байна. Түүнчлэн, 2024 он гарснаар зэсийн баяжмал, хайлуур жоншны баяжмалыг уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалж эхэллээ.

54. Зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспорт нэмэгдлээ. Оюутолгойн гүний уурхайн олборлолт эхэлсэн, төмөр замын тээвэр зохион байгуулалтыг сайжруулсан зэргээс шалтгаалан зэсийн баяжмалын экспорт 2024 оны эхний улиралд 367 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1 хувиар, төмрийн хүдрийн экспорт 1,804 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 28 хувиар тус тус нэмэгдлээ.

55. Өвөлжилт, хаваржилт хүндэрч малын зүй бус хорогдол өндөр байсны улмаас хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспорт буурлаа. Нийт нутгийн ихэнх хэсэгт өвөлжилт, хаваржилт хүндэрч, 6.3 сая толгой мал хоргодсоны улмаас 2024 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад махны экспорт 47 хувиар, ноосны экспорт 49 хувиар, арьс ширний экспорт 26 хувиар тус тус буурлаа.

56. Дотоод эдийн засгийн өсөлт хадгалагдаж, бараа, бүтээгдэхүүний импортын хэмжээг өсгөлөө. Импортын барааны 60 орчим хувь нь дотоодын үйлдвэрлэлийн завсрын хэрэглээнд ашиглагддаг бөгөөд эдийн засаг 8 улирал дараалан өсөлттэй байснаар 2024 оны эхний улиралд импорт 2.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 24.7 хувиар өслөө.

57. Худалдааны түнш орнуудын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт саарснаар импортын барааны үнийн өсөлт бага түвшинд байв. Импорт өмнөх оны мөн үеэс 475 сая ам.доллаар өссөний 95 орчим хувийг тоо хэмжээ, 5 орчим хувийг үнийн өсөлт бүрдүүлсэн байна. Импортын бараа,

бүтээгдэхүүний 36 хувийг бүрдүүлдэг БНХАУ-ын эхний улирлын хэрэглээний үнийн өсөлт 0 хувь байсан нь үнийн өсөлт бага байхад нөлөөллөө.


58. Импортын өсөлтийг барааны бүлгээр авч үзвэл: нийт өсөлтийн 10.7 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 6.8 нэгж хувийг машин механик, тоног төхөөрөмж, 6.7 нэгж хувийг нь аж үйлдвэрийн орц тус тус бүрдүүлсэн байна.

59. Өрхийн бодит орлого болон хэрэглээний зээл өссөнөөр иргэдийн худалдан авах чадвар сайжирч, хэрэглээний бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсэн нь импортын барааны өсөлтийг өдөөлөө. Монгол Улс эцсийн хэрэглээний бүтээгдэхүүний 30 орчим хувийг гадаад улсуудаас худалдан авч хэрэглэж байна. Өрхийн бодит орлого сүүлийн гурван улирал дараалан өндөр өсөж, өрхийн хэрэглээ нэмэгдсэнээр хэрэглээний бүтээгдэхүүний импорт 890 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 30 хувиар өслөө. Түүнчлэн, энэ оны эхний улиралд иргэдийн зээл 37.6 хувиар, тэр дундаа хэрэглээний зээл 2.2 дахин өссөнөөр удаан эдэлгээтэй бараа, бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэв. Мөн Японы иений ханш 1990 оноос хойших түүхэн доод түвшинд хүрч буурснаар манай улсын суудлын автомашины импортын хилийн дундаж үнэ 20.0 орчим хувиар буурсан байна. Улмаар суудлын автомашины импортын тоо хэмжээ 2024 оны эхний улирлын байдлаар 34 мянган ширхэгт хүрч, 2.4 дахин

нэмэгдлээ. Суудлын авто машины импортын өсөлт болон аймаг, сумдын тэмдэглэлт ойн арга хэмжээг угтсан идэвхжил нэмэгдэж, авто бензиний импорт 167 сая ам.долларт хүрч, 46 хувиар өслөө. Харин 2023 онд согтууруулах төрлийн ундааны онцгой албан татварыг нэмэгдүүлсэн ба дотоодын үйлдвэрлэл өссөнөөр энэ төрлийн бүтээгдэхүүний импорт буурсан байна.

60. Зээл олголт, гадаад шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, аж ахуй нэгжүүдийн санхүүгийн эх үүсвэр сайжирч, зарим тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлснөөр тоног төхөөрөмжийн импорт өслөө. Засгийн газраас дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх хүрээнд дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, ашигт малтмал боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх, зарим тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөн банкны салбарын шинээр олгосон зээл 37 хувиар, гадаад шууд хөрөнгө оруулалт 2.2 дахин нэмэгдсэнээр санхүүгийн эх үүсвэр сайжирч, тоног төхөөрөмжийн импорт 624 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 31 хувиар өслөө. Тэр дундаа уул уурхай, боловсруулах, эрчим хүчний салбарт ашиглагдах тоног төхөөрөмжийн импортын өсөлт өндөр байв.

Зураг IV.1. Гадаад худалдааны үзүүлэлт



61. Ипотекийн зээлийн эх үүсвэр нэмэгдэж, цементийн гаалийн албан татварыг бууруулснаар цаашид барилгын материалын импорт өсөхөөр байна. Барилгын салбар энэ оны эхний улиралд 27 хувиар өсөж, барилгын материалын импорт 194 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар өслөө. Хуримтлалын сангаас 500 тэрбум төгрөгийг ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт оруулж, ипотекийн зээлийн эх үүсвэр 1.2 их наяд төгрөгт хүрч нэмэгдсэнээр орон сууцны эрэлт өсөж, цаашид барилгын материалын импортыг нэмэгдүүлэхээр байна. Мөн барилгын үнийн хөөргөдлөөс сэргийлэх хүрээнд цементийн импортод хугацаа, хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэж, гаалийн албан татварыг 20 хувь байсныг 5 хувь болгож бууруулсан.

62. Хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүний импорт энэ онд үргэлжлэн өсөх хандлагатай байна. Хөдөө аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор мал, амьтны тэжээл, улаанбуудайн гурилын импортын хэмжээнд хязгаар квот тогтоохгүй, хугацаа заахгүй байхаар шийдвэрлэж, 2024 оны 5 дугаар сараас эхлэн гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн өөрчлөлт батлагдсан.

ШИГТГЭЭ 5. ГУРИЛЫН ГААЛИЙН ТАТВАР

Гурилын импортын тоо хэмжээний зохицуулалтын талаар

Мах, гурил, сүү, сүүн бүтээгдэхүүн нь улирлын онцлогоос хамаарч үйлдвэрлэл, хангамжийн түвшин ялгаатай байдаг бөгөөд өрхийн өргөн хэрэглээний гол хүнс юм. Хүнсний тухай хуулийн 3.1.6-д стратегийн хүнсний бүтээгдэхүүнд гурил, тарианы үр, сүү, малын мах, ундны ус гэж заасан байдаг. Мөн тус хуулийн 6.7-д Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүнсний эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, гаргасан зөвлөмжийг үндэслэн тогтоохоор заасан байдаг. Иймд стратегийн хүнс болох гурил, ундны ус, тарианы үр, малын мах нь тоо хэмжээний зохицуулалттай бүтээгдэхүүн бөгөөд гурил болон түүний орц болох улаанбуудайн үр нь хоёул стратегийн хүнсэнд багтдагаараа онцлог юм. Манай улс 2018 оноос өмнө гурилын импортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоодог байсан. Харин Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлцээрийн 11 дүгээр зүйл, Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн 4.2 дугаар зүйлд заасантай уялдуулан 2018 онд Баяжуулсан хүнсний тухай хуулийг батлан, 2019 оноос импортлох гурилд 7 төрлийн аминдэм, эрдсээр баяжуулсан байх шаардлага тавьсан. Үүний дагуу баяжуулсан гурилын импортын тоо хэмжээнд хязгаарлалт тогтоохгүй, Баяжуулсан хүнсний тухай хуулийн шаардлагыг ханган импортлох зохицуулалтыг 2020 оноос эхлэн мөрдүүлэн ажиллаж байна.


Цаг үеийн нөхцөл байдал

Монгол Улсын хувьд 2023 оны байдлаар нийт өрхийн 31 хувь нь хөдөө, тэдгээрийн 62 хувь нь малчин өрх байна. 2024 оны 3 дугаар сарын байдлаар 14 аймгийн 46 сум мөсөн зудтай, 17 аймгийн 135 сум цагаан зуд болж өвөлжилт хүндэрснээр малчин өрхийн амьжиргааны түвшин буурах эрсдэл үүссэний дээр зам, даваа хаагдсаны улмаас нийслэлээс хийгддэг хүнсний тээвэр тасалдаж, нийлүүлэлтийн гаралтай үнэ өсөх нөхцөл байдал үүссэн. Гурилын үнэ нь цар тахал, ОХУ-Украины дайн, БНХАУ-ын "Тэг Ковид" бодлого зэргээс 2024 оны 03 дугаар сарын байдлаар цар тахлын өмнөх үеэс 2.1 дахин, инфляцын оргил үе болох 2022 онтой харьцуулахад 67 хувиар тус тус өссөний дээр баруун бүс нутагт гурилын үйлдвэргүй тул гурилын нийлүүлэлт тасалдаж эхэлснээр гурилын үнэ дахин нэмэгдэх нөхцөл үүссэн.


Иймд хөдөө орон нутагт гурил, гурилан бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой хадгалах, үнийн өсөлтөөс сэргийлэх арга хэмжээний хүрээнд импортын тоо хэмжээг тогтоох байдлаар баяжуулаагүй гурил оруулж ирэх нөхцөлийг бүрдүүлж, богино хугацааны тасалдлыг хангасан. Мөн гурилын үнийн өсөлтийг бууруулж, хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд гурилыг 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн гаалийн татвараас чөлөөллөө.

Зураг IV.2. Гурилын үйлдвэрлэл, хэрэглээ

1. Гурилын үйлдвэрлэл, импорт, нийт хэрэглээ болон үнэ
(мянган тонн: зүүн тэнхлэг, төгрөг: баруун тэнхлэг)



2. Буудай тариалсан талбай болон гурилын үйлдвэрлэл, импорт
(мянган тонн, мянган га)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Үндэсний статистикийн хороо

ШИГТГЭЭ 6. ЦЕМЕНТИЙН ГААЛИЙН ТАТВАР

Монгол Улсад 2024 оны байдлаар цементийн 7 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд жилд 4.5 сая тонн цемент үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай бөгөөд 2023 оны байдлаар улсын нийт хэрэглээний 89 хувийг дотоодын үйлдвэрээс хангаж байна. Чанарын шаардлага хангахгүй цементийн импортоос сэргийлэх, дотоодын үйлдвэрлэгчдийг хамгаалах зорилгоор цементийн гаалийн албан татвар 20 хувь байдаг.


2022 онд дотоодын цементийн 5 үйлдвэрийн 2 нь засварын ажил эхлүүлсэнтэй холбоотойгоор нийлүүлэлтээ зогсоож, бусад 3 үйлдвэрлэгчийн үйлдвэрлэж буй цементийн дийлэнх хэсэг нь улсын чанартай томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын ажилд нийлүүлэгдэж байсантай холбоотойгоор жижиглэнгийн зах зээлд хомсдол үүсэж, цементийн үнийн өсөлт эрчимжсэн.

Эрэлт талаас орон сууцны барилгын эрэлт эрчимжих хүлээлт үүссэн. Тухайлбал, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 4 сарын 19-ны өдөр баталснаар хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг орон сууц, боловсрол, эрүүл мэндийн салбарт зарцуулахаар тусгасан. 2024 онд ипотекийн зээлийн эх үүсвэрт хуримтлалын сангаас 500 тэрбум төгрөгийг оруулсан.

Ипотекийн зээлийн санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотойгоор зээл олголт сайжирч, орон сууцны эрэлт нэмэгдэн барилгын салбарт үнийн хөөргөдөл үүсэх эрсдэлтэй тул барилгын ихэнх хувьд ашиглагдах цементийн импортын тоо хэмжээнд хязгаар тогтоохгүй, мөн Засгийн газрын 2024 оны 188 дугаар тогтоолоор цементийн гаалийн албан татварыг 2024 оны 5 сарын 1-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл 20 хувиас 5 хувь болгож бууруулах шийдвэр гарсан.

Зураг IV.3. Цементийн үйлдвэрлэл, хэрэглээ

Цементийн үйлдвэрлэл, импорт, нийт хэрэглээ
(мянган тонн)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Барилга хот байгуулалтын яам, Гаалийн ерөнхий газар


ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

63. Урсгал данс алдагдалтай гарсан ч санхүүгийн дансны ашиг нэмэгдэж, төлбөрийн тэнцэл 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс сайжирлаа. Нүүрсний үнийн бууралтаас шалтгаалан барааны экспорт өмнөх оны мөн үеэс ердөө 82 сая ам.доллороор нэмэгдсэн ч тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмжийн импортын өсөлттэй холбоотойгоор барааны импорт 0.6 тэрбум ам.доллороор өссөнөөр урсгал данс алдагдалтай гарлаа. Гэсэн хэдий ч шууд хөрөнгө оруулалт болон Засгийн газрын зээлийн цэвэр орох урсгал нэмэгдэхийн зэрэгцээ худалдааны зээлийн эргэн төлөлттэй холбоотой гадаад валютын гарах урсгал буурснаар өмнөх оны эхний улиралд 0.5 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан санхүүгийн дансны тэнцэл 2024 оны эхний улиралд 0.9 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Улмаар төлбөрийн тэнцэл 2024 оны эхний улиралд 0.4 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 4.7 дахин сайжирлаа.

64. Гадаад бондын хуваарьт төлбөрийг амжилттай төлж барагдуулж, олон улсын зах зээлд шинэ бондууд арилжлаа. Монгол Улсын Засгийн газар 2017 онд гаргасан 600 сая ам.долларын Хуралдай бондын үлдэгдэл төлбөрийг 2024 оны 3 дугаар сард амжилттай төлж барагдууллаа. Түүнчлэн 2024 оны 1 дүгээр сард “МИК ОССК” ХХК 225 сая ам.долларын бондыг, 2024 оны 3 дугаар сард Монгол Улсын Хөгжлийн Банк 200 сая ам.долларын бондыг тус тус олон улсын зах зээлд амжилттай арилжлаа.

65. Гадаад валютын нөөц үргэлжлэн нэмэгдэж, төгрөгийн ханш тогтвортой байв. Төлбөрийн тэнцэл ашигтай гарснаар гадаад валютын нөөц 2024 оны эхний улирлын эцэст өмнөх оны мөн үеэс 52.7 хувиар өсөж, 5,250 сая ам.долларт хүрлээ. Энэ нь бараа, үйлчилгээний импортын 4.4 сарын хэрэгцээг хангах түвшин буюу ОУВС-гийн АРА хэмжүүрийн 103 хувьтай тэнцэж байна. Улмаар төгрөгийн бодит ханшийн индекс 2024 оны эхний улирлын эцэст өмнөх оны мөн үеэс өслөө.

Зураг IV.4. Урсгал дансны тэнцэл, гадаад валютын нөөц, төгрөгийн ханш




66. Үндэсний нийт хөрөнгө оруулалт нийт хадгаламжаас өндөр байв. Урсгал дансны тэнцлийг тухайн улсын нийт хадгаламж болон хөрөнгө оруулалтын зөрүүгээр мөн тайлбарладаг. Нийт эдийн засгийг Засгийн газар болон хувийн секторт хуваан харвал сүүлийн 6 улирал дараалан Засгийн газрын хадгаламж хөрөнгө оруулалтаасаа давсан байна. Уул уурхайн экспортын өсөлттэй холбоотой төсвийн орлогын өсөлт Засгийн газрын хадгаламж нэмэгдэхэд нөлөөлсөн бол хувийн секторын хөрөнгө оруулалтын хэрэгцээ хадгаламжаасаа өндөр хэвээр байна.

67. Гадаад хөрөнгө оруулалтын позиц сул байгаа нь манай улс гадаад шокоос үүдэлтэй хямралд өртөх эрсдэл өндөр байгааг харуулж байна. Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц нь гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн

санхүүгийн хөрөнгө болон Монгол Улс бусад улсад төлөх үүрэг бүхий өр төлбөрийн зөрүүг харуулдаг. Манай улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2024 оны эхний улирлын байдлаар -41.5 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий -200 хувьтай тэнцэж байна. Өөрөөр хэлбэл, Монгол улсад байршиж буй, гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн дүн гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгөөс хэт өндөр байгаа бөгөөд энэ нь манай улс гадаад шокоос үүдэлтэй хямралд өртөх эрсдэл өндөр байгааг харуулж байна. Урсгал дансны алдагдлыг хязгаарлаж, алдагдлыг санхүүжүүлэхэд шаардагдах өр төлбөр үргэлжлэн хуримтлагдахаас сэргийлэх нь гадаад хөрөнгө оруулалтын позицыг сайжруулах, гадаад сөрөг шокт өртөх эмзэг байдлыг бууруулахад чухал нөлөөтэй (Зураг IV.5)

Зураг IV.5. Гадаад хөрөнгө оруулалтын позиц




68. Хувийн хэвшлийн гадаад бонд, шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл өсөж, Монгол Улсын нийт гадаад өр нэмэгдлээ. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2024 оны эхний улирлын эцэст 35 тэрбум ам.доллар болж, өмнөх улирлаас 0.4 тэрбум ам.доллароор нэмэгдсэн ч эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ 168 хувь болж, өмнөх улирлаас 5.5 нэгж хувиар буурлаа. Хуралдай бондын эргэн төлөлттэй холбоотойгоор Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл өмнөх улирлаас 0.1 тэрбум ам.доллароор буурсан бол банкнаас бусад салбарын гадаад бонд болон шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдэл өмнөх улирлаас 0.6 тэрбум ам.доллароор нэмэгдлээ.

69. Нийт гадаад өрийн дийлэнх хэсгийг хувийн хэвшлийн өр бүрдүүлж байна. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдлийн 72 хувийг хувийн

хэвшлийн өр, 23 хувийг Засгийн газрын өр, 5 хувийг төв банкны өр тус тус бүрдүүлж байна. Харин хувийн хэвшлийн гадаад өрийн дийлэнх буюу 78 хувийг уул уурхайн салбар, 9 хувийг санхүүгийн салбар, 4 хувийг худалдааны салбарын өр, үлдсэн 10 хувийг бусад 18 салбарын өр бүрдүүлж байна.

70. Гадаад өрийн динамик дунд хугацаанд харьцангуй тогтвортой байгаа ч ханш, урсгал дансны тэнцлийн шокуудад эмзэг байна. Суурь төсөөлөөр экспорт болон ДНБ-ий өсөлтийн эерэг нөлөөгөөр ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ дунд хугацаанд тогтвортой буурахаар байна. Гэсэн хэдий ч ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ ханшийн өөрчлөлт, урсгал дансны тэнцлийн шокуудад эмзэг байна. Суурь төсөөлөлтэй харьцуулахад гадаад өр болон ДНБ-ий харьцаа урсгал дансны тэнцэл 1/2 стандарт хазайлтаар буурахад 14.2 нэгж хувиар, төгрөгийн ханш 10 хувиар сулрахад 23.8 нэгж хувиар тус тус өсөхөөр байна (Зураг IV.7).

Зураг IV.6. Гадаад өр




Зураг IV.7. Гадаад өрийн тогтвортой байдал

ГАДААД ӨР												
(өөрөөр тэмдэглэггүй бол ДНБ-д эзлэх хувиар)												
	Гүйцэтгэл						Төсөөлөл					Өр тогтворжуулах урсгал дансны үндсэн тэнцэл
	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	
Гадаад өр: Суурь төсөөлөл	217.9	216.1	243.1	221.1	194.4	174.0	152.2	133.5	126.9	119.3	111.5	-7.9
Гадаад өрийн өөрчлөлт	-21.5	-1.7	26.9	-21.9	-26.7	-20.5	-21.8	-18.6	-6.6	-7.6	-7.8	
Өр үүсгэх урсгалууд	-20.9	-8.6	14.9	-25.3	-11.5	-28.7	-30.2	-28.7	-16.3	-17.6	-16.1	
Урсгал дансны алдагдал, хүүгийн төлбөрийг хассанаар	7.7	5.5	-4.9	5.6	4.9	-11.1	-10.8	-11.8	-11.6	-11.4	-7.7	
Өрийн бус хөрөнгийн цэвэр орох урсгал (-)	-6.8	-8.1	-4.6	-7.7	-0.9	-1.4	-1.1	-1.1	-1.0	-0.9	-1.0	
Өрийн автомат динамик 1/	-21.8	-6.0	24.4	-23.2	-15.6	-16.2	-18.4	-15.9	-3.6	-5.3	-7.3	
Нэрлэсэн хүүгийн түвшний нөлөө	9.0	9.7	10.0	8.2	8.5	10.5	7.8	6.9	6.3	5.6	4.4	
Бодит ДНБ-ий өсөлтийн нөлөө	-16.2	-11.3	10.5	-3.5	-9.9	-11.8	-8.9	-10.3	-8.0	-7.5	-7.0	
Үнэ, валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	-14.7	-4.5	3.9	-27.9	-14.2	-14.9	-17.3	-12.4	-2.0	-3.3	-4.8	
Бусад	-0.6	6.9	12.1	3.4	-15.2	8.2	8.4	10.1	9.7	10.0	8.3	
Гадаад өр-экспорт харьцаа (хувь)	374.5	364.8	423.3	377.7	303.4	223.0	197.9	181.8	170.3	160.8	160.7	
Гадаад өр: Гол хувьсагчид түүхэн дундаж түвшинд байх үед 2/							180.9	191.0	200.9	211.7	220.8	-4.1
							түүхэн дундаж	стандарт хазайлт				
Бодит ДНБ-ий өсөлт (хувь)	7.7	5.6	-4.6	1.6	5.0	7.0	4.0	3.8				
ДНБ-ий дефлятор (ам.доллараар, өөрчлөлтийн хувь)	6.5	2.1	-1.8	13.0	6.8	8.3	1.0	7.5				
Нэрлэсэн гадаад хүү (хувь)	4.3	4.8	4.3	3.9	4.3	6.3	4.6	0.6				
Экспортын өсөлт (ам.доллараар, хувь)	12.8	9.7	-9.1	17.1	22.8	41.1	14.5	17.6				
Импортын өсөлт (ам.доллараар, хувь)	37.5	3.1	-20.6	26.1	30.9	11.8	7.0	21.9				
Урсгал дансны тэнцэл, хүүгийн төлбөр хассанаар	-7.7	-5.5	4.9	-5.6	-4.9	11.1	-1.4	6.3				
Өрийн бус хөрөнгийн цэвэр орох урсгал	6.8	8.1	4.6	7.7	0.9	1.4	3.2	4.2				


1/ДНБ, гадаад өрийн хүү, ханш зэрэг үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөс шалтгаалах гадаад өрийн хэлбэлзэл

2/Гол хувьсагчид буюу урсгал дансны үндсэн тэнцэл, өрийн бус хөрөнгийн цэвэр орох урсгал, бодит ДНБ-ий жилийн өөрчлөлт, ДНБ-ий дефлятор, нэрлэсэн гадаад хүүний үзүүлэлтүүд сүүлийн 10 жилийн түүхэн дундажтай тэнцүү байхаар тооцов.


1. Суурь болон түүхэн дундаж хувилбар



2. Хүүгийн шок




3. ДНБ-ий өсөлтийн шок




4. Урсгал дансны шок



5. Хавсарсан шок (хүү, урсгал данс, ДНБ-ий өсөлт)



6. Ханшийн шок



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Түүхэн дундаж, стандарт хазайлыг сүүлийн 10 жилийн үзүүлэлтээр тооцов. Урсгал данс, ДНБ-ий өсөлтийн дан шокийг 1/2 стандарт хазайлтаар, хавсарсан шокийг 1/4 стандарт хазайлтаар, хүүгийн шокийг суурь түвшнээс 1 нэгж хувиар өсөхөөр, ханшийн шокийг 10 хувийн сулралаар тус тус тооцов.

БҮЛЭГ V

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

- 5.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ
- 5.2 ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХАНДЛАГА

V. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

ТОЙМ

Дэлхийн эдийн засгийн идэвхжил 2024 оны эхний саруудад нэмэгдэж, олон улсын байгууллагууд дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг сайжрууллаа. Түүхий эдийн зах зээлд геополитикийн тогтворгүй байдал, нийлүүлэлтийн нөхцөл байдлаас шалтгаалан алт, зэс, коксжих нүүрс, газрын тосны үнэ өссөн бол төмрийн баяжмалын үнэ буурлаа.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

71. Дэлхийн эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байна. Өнгөрсөн оны сүүлийн хагаст саараад байсан дэлхийн эдийн засгийн идэвхжил 2024 оны эхний саруудад сэргэлээ. S&P дэлхийн худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 5 дугаар сард сүүлийн 12 сарын хамгийн дээд түвшинд хүрсэн бөгөөд өнгөрсөн оны 9 дүгээр сард 3.5 хувиар агшаад байсан дэлхийн барааны худалдаа 2024 оны 2 дугаар сард 1.2 хувиар өссөн байна.

72. Олон улсын байгууллагууд дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг сайжруулав. Дэлхийн эдийн засгийн гүйцэтгэл төсөөллөөс сайн байсантай холбоотойгоор 2024 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг ОУВС 2024 оны 4 дүгээр сард 3.2 хувь буюу өмнөх төсөөллөөс 0.1 нэгж хувиар нэмэгдүүлсэн бол ЭЗХАХБ 2024 оны 5 дугаар сард 3.1 хувь болгон өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар тус тус нэмэгдүүллээ. Геополитикийн тогтворгүй байдал, үнийн өсөлт, мөнгөний бодлогын төлөв зэрэг хүчин зүйлс эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж байгаа ч дэлхийн эдийн засгийн өсөлт 2024-2025 онд тогтвортой байна гэж олон улсын байгууллагууд үзэж байна.

73. Томоохон төв банкнууд бодлогын хүүг хэвээр хадгалав. АНУ-ын эдийн засаг хувийн хэрэглээ, үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр 2024 оны эхний улиралд 1.6 хувиар өссөн ба суурь инфляц 2024 оны 4 дүгээр сард 3.6 хувьд

хүрч, 2021 оны 4 дүгээр сараас хойших хамгийн бага түвшинд хүрлээ. Гэсэн хэдий ч Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүг 5.25-5.00 хувьд хэвээр хадгаллаа. Евро бүсийн инфляц 2024 оны 4 дүгээр сард 2.4 хувьд хүрч, сүүлийн 7 сар дараалан 3 хувиас бага түвшинд хадгалагдсан ч 2024 оны 5 дугаар сарын байдлаар Европын төв банк бодлогын хүүг 2023 оны 9 дүгээр сараас хойш хэвээр хадгаллаа.

74. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт эрчимжив. Өнгөрсөн онд 5.2 хувиар өссөн БНХАУ-ын эдийн засаг 2024 оны эхний улиралд 5.3 хувиар тэлсэн ба аж үйлдвэр болон үйлчилгээний салбарын идэвхжил эдийн засгийн өсөлтийг голлон дэмжлээ. Гэсэн хэдий ч 2024 оны эхний улиралд үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт 9.5 хувиар, борлуулалт 27.6 хувиар тус тус буурч, салбарын уналт үргэлжилсэн хэвээр байна. Бодлого боловсруулагчдын зүгээс үл хөдлөх хөрөнгийн салбарыг дэмжих хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг тэлж, ипотекийн зээлийн хүүгийн доод хязгаарыг цуцалж, урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээг дахин бууруулахыг зэрэгцээ борлуулагдаагүй орон сууцуудыг худалдан авахад чиглэсэн 300 тэрбум юанийн хөтөлбөрийг зарлаад байна. Тус улсын эдийн засгийн өсөлт төсөөллөөс өндөр байсантай холбоотойгоор ОУВС 2024 оны 5 дугаар сард тус улсын эдийн засгийн 2024 оны өсөлтийн төсөөллийг 5.0 хувь, 2025 оны өсөлтийн төсөөллийг 4.5 хувь болгож, өмнөх 4 дүгээр сарын төсөөллөөс тус бүр 0.4 нэгж хувиар нэмэгдүүллээд байна.

75. ОХУ-ын эдийн засаг өсөлттэй хэвээр байна.

ОХУ-ын эдийн засаг 2024 оны эхний улиралд 5.4 хувиар өссөн байна. Эдийн засгийн өсөлтөд Украинд болж буй дайнтай холбоотой цэрэг армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн тэлэлт голлон нөлөөллөө. Экспорт 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар, 2022 оны мөн үеэс 36.7 хувиар, импорт өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар тус тус буурсан байна. Экспортын бууралтад тус улсын газрын тос, байгалийн хийн үнэ, биет хэмжээний бууралт гол нөлөө үзүүлсэн байна. Тайлант хугацаанд инфляцын түвшин 2023 оны 12 дугаар сараас хойш аажмаар өсөж, төв банкны зорилтот түвшин 4 хувиас давсан хэвээр буюу сүүлийн нэг жилийн дээд түвшин 7.7 хувийг хадгалсан хэвээр байлаа. Геополитикийн нөхцөл байдлаас улбаатай олон улсаас тус улсын эсрэг авч хэрэгжүүлсэн хориг арга хэмжээнээс шалтгаалан дотоод эрэлтийг нэмэгдүүлсэнтэй холбоотой аж үйлдвэрийн салбарын тэлэлтийн үзүүлэлт болох худалдан авалтын менежерийн индекс

2024 оны 3 дугаар сард 55.7 болж, сүүлийн 7 жилийн хугацаанд хамгийн өндөр тэлсэн байна. Бодит аж үйлдвэрлэлийн өсөлт 2024 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өссөн нь сүүлийн 2 жилийн хугацааны хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Ийнхүү дотоод эрэлтээс улбаатай шинэ захиалгын хэмжээ огцом нэмэгдсэн нь ажил эрхлэлтийг дэмжиж, бараа материалын худалдан авалтыг нэмэгдүүлсэн нь аж үйлдвэрийн салбарын тэлэлтэд гол нөлөө үзүүлсэн байна. ОХУ-ын засгийн газар батлан хамгаалах салбарт асар их зардал гаргаж, дотоодын бизнесээ хамгаалахад мөнгө зарцуулж байгаа тул өнгөрсөн онд дотоодын нийт бүтээгдэхүүн 3.6 хувиар өссөн нь тус улсын эдийн засгийн яамны 2.8 хувиар тэлэх хүлээлтээс давсан боловч эдийн засгийн өсөлт 2024 онд 2.9 хувь, 2025 болон 2026 онд 2.0 хувиас бага болж удааширна гэж тус улсын бодлого боловсруулагчид таамаглаж байна.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХАНДЛАГА

76. Алтны үнэ 2024 оны эхний улиралд 2074 ам.доллар/унц болж, өмнөх оны эцсээс 6 хувиар өссөн байна. Геополитикийн нөхцөл байдал хүндэрч байгаа энэ үед төв банкнууд алтны худалдан авалтаа нэмэгдүүлж байгаа нь алтны үнэ өсөхөд голлон нөлөөллөө.

77. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн дундаж үнэ 2024 оны эхний улиралд 8,443 ам.доллар/тонн болж, өмнөх оны эцсээс 0.4 хувиар өссөн байна. Чип үйлдвэрлэлд зориулсан дэд бүтцийн санхүүжилтийг АНУ, БНХАУ зэрэг томоохон улсууд нэмэгдүүлж байгаа нь зэсийн үнэ өсөхөд голлон нөлөөллөө.

78. Зүүн хойд Хятадын 62 хувийн агууламжтай төмрийн баяжмалын дундаж үнэ 2024 оны эхний улиралд 124 ам.доллар/тонн болж, өмнөх оны эцсээс 11 хувиар буурсан байна. Австрали, Бразил


зэрэг улсуудын нийлүүлэлт нэмэгдсэн, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар сэргэж чадахгүй байгаа зэрэг нь төмрийн баяжмалын үнэ буурахад голлон нөлөөллөө.

79. Австралийн сайн чанарын коксжих нүүрсний дундаж үнэ 2024 оны эхний улиралд 312 ам.доллар/тонн болж, өмнөх оны эцсээс 5.2 хувиар өссөн байна. БНХАУ нь Австралийн коксжих нүүрсний импортын хоригийг цуцалсан, Энэтхэгийн нүүрсний эрэлт нэмэгдсэн зэрэг нь коксжих нүүрсний үнэ нэмэгдэхэд голлон нөлөөллөө.


80. Брент төрлийн газрын тосны дундаж үнэ 2024 оны эхний улиралд 80 ам.доллар/баррель болж, өмнөх оны эцсээс 2.9 хувиар өссөн байна. ОПЕК-ийн гишүүн орнууд газрын тосны нийлүүлэлтийг эрчимтэй багасгаж эхэлсэн нь газрын тосны үнэ өсөхөд голлон нөлөөллөө.

Зураг V.1. Түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ


1. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн гүйцэтгэл (\$/тонн)




2. Зүүн хойд БНХАУ дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмалын гүйцэтгэл (\$/тонн)



3. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний гүйцэтгэл (\$/тонн)



4. Брент газрын тосны гүйцэтгэл (\$/баррель)



Эх сурвалж: Блүүмберг

БҮЛЭГ VI
ЭРСДЭЛ

ЭРСДЭЛ

НЭГ. ЗУД Нийт нутгийн 80 хувийг хамарсан зудын улмаас улсын хэмжээнд 6.3 сая толгой мал хорогдож, бойжуулсан төлийн тоо 2023 оны эцэст 28 хувиар, 2024 оны эхэнд 38 хувиар тус тус буурлаа. Зудын улмаас ирэх онуудад махны нийлүүлэлт буурч, хүнсний инфляц өсөх, мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл багасаж, малчдын амьжиргаа дордон хэрэглээ хумигдах, цаашлаад эдийн засаг дахь хөрөнгийн хуримтлалд сөрөг нөлөө үзүүлж, өсөлтийг сааруулах эрсдэлтэй байна.

ХОЁР. ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХЭЛБЭЛЗЭЛ Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлаас шалтгаалсан эрэлт, нийлүүлэлтийн тогтворгүй байдал манай улсын экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн гадаад зах зээл дээрх үнийн хэлбэлзлийг нэмэгдүүлж, манай улсын экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Мөн түүхий эдийн дэлхийн зах зээлд өндөр нөлөө бүхий БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж, тус улсын эдийн засгийн өсөлт хүлээлтээс доогуур байх нь манай улсын экспортын түүхий эдийн эрэлт, үнийг бууруулах замаар экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй.

ГУРАВ. ГЕОПОЛИТИКИЙН ТОГТВОРГҮЙ БАЙДАЛ ОХУ-Украины нөхцөл байдал даамжрах, Газын зурвас, Израйл орчмын бүс нутгийн мөргөлдөөн хурцдах, Улаан тэнгист халдлага үргэлжлэх зэрэг эрсдэлүүд авто бензин, улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг манай улсын импортын голлох бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж болзошгүй байна.

ДӨРӨВ. ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАСРАЛТГҮЙ, НАЙДВАРТАЙ БАЙДАЛ Эрчим хүч нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь хүчин зүйл боловч манай улс дотоодын цахилгаан хүчний хэрэглээний 20 орчим хувийг импортолж байна. Мөн манай улсын эрчим хүчний хангамж нь төвлөрсөн системтэй ба станцуудын насжилт өндөр, түгээлтийн шугам, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч, элэгдсэн эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна. Эрчим хүчний нийлүүлэлт тасалдах нь бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй.

ТАВ. НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТАСАЛДАЛ Монгол улсын нийт импортын 80 орчим хувь нь Тяньжин боомтоор дамжин, төмөр замаар тээвэрлэгдэн Замын-Үүд боомтоор орж ирдэг. КОВИД-19 цар тахлын үед Тяньжин боомтод 9,000 гаруй чингэлэг бөөгнөрч, импортын бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдал үүссэнээс шалтгаалан инфляц 16.9 хувьд хүрсний 8.9 нэгж хувь буюу 55 гаруй хувийг импортын инфляц бүрдүүлж байв. Тяньжин боомтоос өдөрт гарах галт тэрэгний тоо буурсантай холбоотойгоор энгийн үед 3000 орчим байдаг тус боомт дээрх чингэлгийн тоо 2024 оны 6 дугаар сарын байдлаар 5,000 даваад байгаа нь нийлүүлэлтийн хугацааг уртасгаж, бараа бүтээгдэхүүний үнэ өсөх эрсдэлийг дагуулж байна.

ХАВСРАЛТ

ХҮСНЭГТ 0.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024Q1
БОДИТ СЕКТОР					
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөгөөр)	37,453	43,555	53,852	68,872	16,454
Бодит ДНБ өсөлт - үйлдвэрлэл (хувиар)	-4.6	1.6	5.0	7.0	7.8
Бодит ДНБ өсөлт - эцсийн ашиглалт (хувиар)	-4.4	1.6	5.0	7.1	7.8
Дотоод эрэлтийн оролцоо (нэгж хувиар)	-12.6	17.6	11.4	1.9	27.2
Бараа, үйлчилгээний экспортын оролцоо (нэгж хувиар)	-2.7	-7.5	13.9	23.3	-7.5
Бараа, үйлчилгээний импортын оролцоо (нэгж хувиар)	11.0	-8.5	-20.3	-18.0	-11.9
Бодит ДНБ-ий өсөлт дэх оролцоо (нэгж хувиар)					
Эцсийн хэрэглээ	3.6	-2.3	6.5	6.1	23.4
Өрхийн хэрэглээ	1.3	-4.0	5.1	4.8	14.6
Төрийн байгууллагын хэрэглээ	2.2	1.7	1.4	1.3	8.8
Хөрөнгийн нийт хуримтлал	-16.2	19.9	4.9	-4.3	3.8
Цэвэр экспорт	8.2	-16.0	-6.4	5.2	-19.4
(ДНБ-д эзлэх хувиар)					
Хадгаламж ба хөрөнгө оруулалт					
Үндэсний нийт хадгаламж	17.3	22.3	28.7	31.2	20.1
Үндэсний нийт хөрөнгө оруулалт	22.1	35.8	41.5	31.7	24.8
Хувийн секторын үндсэн хөрөнгийн хуримтлал	14.1	29.1	34.6	24.3	19.8
Засгийн газрын үндсэн хөрөнгийн хуримтлал	8.0	6.7	6.9	7.3	5.0
ҮНИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	2.3	13.8	13.2	7.9	7.0
Зэсийн үнэ* (\$/тонн)	6,178	9,315	8,815	8,479	8,443
Алтны үнэ* (\$/трой. унци)	1,772	1,799	1,802	1,943	2,074
Газрын тосны үнэ* (\$/баррел, Brent)	50	61	82	79	80
ДНБ дефлятор (хувиар)	3.7	14.4	17.7	19.5	10.7
(тэрбум төгрөгөөр)					
НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
Нийт орлого ба тусламжийн дүн	10,444	14,306	18,522	24,310	7,673
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	9,464	12,711	17,127	23,218	7,322
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	13,904	15,630	18,160	22,454	5,695
Нийт тэнцэл	-3,460	-1,324	362	1,856	1,978
Нийт үндсэн тэнцэл	-2,521	-488	1,160	2,987	2,380
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-4,440	-2,919	-1,033	763	1,627
Тэнцвэржүүлсэн үндсэн тэнцэл	-3,501	-2,083	-235	1,895	2,028
ЗГ-ын нийт өр (ӨҮЦ)	62.3	50.8	52.4	38.6	33.7
ЗГ-ын нийт өр (нэрлэсэн, тэрбум төгрөгөөр)	27,899	26,918	31,965	30,774	29,767
МӨНГӨНИЙ СЕКТОР					
M2 мөнгөний өсөлт (хувиар)	16.2	13.8	6.5	26.8	20.9
Нөөц мөнгөний өсөлт (хувиар)	-12.7	6.5	39.9	7.4	11.7
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	1.5	1.6	1.8	1.8	1.9
Мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	5.4	5.8	4.4	5.2	6.1
Зээлийн өсөлт** (хувиар)	-4.0	18.5	7.5	22.7	22.3
(сая ам.доллаароор)					
ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ					
Төлбөрийн тэнцэл	787	-222	-727	1,457	373
Урсгал дансны тэнцэл	-675	-2,108	-2,304	121	-251
ГВАН	4,534	4,366	3,400	4,921	5,250
сарын бараа, үйлчилгээний импортын хүрэлцээ	7.4	5.7	3.4	4.4	17.3
Гадаад валютын ханш					
Валютын ханш USD/MNT (дунджаар)	2,813	2,849	3,140	3,466	3,392
Валютын ханш USD/MNT (хугацааны эцсээр)	2,850	2,849	3,445	3,411	3,376
Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	43.0	41.3	38.8	37.6	39.4
Бодит үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	102.9	103.6	106.9	112.4	119.2

*Bloomberg Terminal

**Ипотекийн зээлээр баталгаажсан бондыг оруулсан дүн

ХҮСНЭГТ 0.2. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024Q1
Нэрлэсэн ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	37,453	43,555	53,852	68,872	16,454
Бодит ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	26,655	27,092	28,455	30,454	6,065
	(өсөлт, хувиар)				
Бодит ДНБ-ий өсөлт	-4.6	1.6	5.0	7.0	7.8
Уул уурхайн салбарын өсөлт	-9.9	0.8	-15.3	23.4	13.1
Уул уурхайн бус салбарын өсөлт	-3.7	1.8	8.2	5.0	6.9
Хөдөө аж ахуй	5.8	-5.5	12.0	-8.9	-31.4
Уул уурхай	-9.9	0.8	-15.3	23.4	13.1
Боловсруулах аж үйлдвэр	3.4	-0.9	6.1	5.1	6.3
Цахилгаан дулаан	1.8	9.4	3.3	5.0	7.7
Барилга	-3.2	-22.8	8.2	0.6	27.7
Бөөний болон жижиглэн худалдаа	-12.5	5.8	10.1	5.7	6.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-18.2	-7.3	9.2	39.3	27.2
Мэдээлэл, холбоо	5.2	20.7	6.6	16.4	26.3
Бусад үйл ажиллагаа	-2.6	3.8	5.4	5.2	3.7
Цэвэр татвар	-9.4	12.2	11.5	6.8	13.1
Дефлятор	3.7	14.4	17.7	19.5	10.7
	(нэгж хувиар)				
ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо					
Хөдөө аж ахуй	0.8	-0.8	1.7	-1.3	-1.3
Уул уурхай	-1.4	0.1	-2.1	2.6	1.9
Боловсруулах аж үйлдвэр	0.3	-0.1	0.5	0.4	0.4
Цахилгаан дулаан	0.0	0.2	0.1	0.1	0.3
Барилга	-0.1	-0.9	0.2	0.0	0.2
Бөөний болон жижиглэн худалдаа	-1.4	0.6	1.1	0.7	0.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-1.0	-0.3	0.4	1.8	1.3
Мэдээлэл, холбоо	0.1	0.5	0.2	0.5	0.9
Бусад үйл ажиллагаа	-0.7	1.1	1.6	1.5	1.3
Цэвэр татвар	-1.1	1.3	1.4	0.9	2.1
	(тэрбум төгрөгөөр)				
Нэрлэсэн ДНБ (эцсийн ашиглалтын аргаар)	37,883	44,703	54,878	70,444	16,853
Анхдагч орлого	-3,526	-6,359	-5,072	-7,738	-1,693
Үндэсний нийт орлого	34,357	38,344	49,806	62,706	15,160
Хоёрдогч орлого	769	1,223	1,363	1,378	592
Үндэсний нийт цэвэр орлого	35,126	39,566	51,169	64,084	15,752
Нийт дотоод эрэлт	36,953	45,574	58,219	64,392	16,545
Үндэсний хадгаламж	6,556	9,985	15,747	21,997	3,385
Үндэсний хөрөнгө оруулалт	8,383	15,993	22,796	22,305	4,178
Хадгаламж - Хөрөнгө оруулалтын тэнцэл	-1,827	-6,008	-7,050	-308	-793
	(ДНБ-д эзлэх хувиар)				
Нийт дотоод эрэлт	97.5	101.9	106.1	91.4	98.2
Эцсийн хэрэглээ	75.4	66.2	64.5	59.7	73.4
Өрхийн хэрэглээ	59.8	51.6	50.9	46.8	53.6
Төрийн байгууллагын хэрэглээ	15.6	14.5	13.7	13.0	19.8
Хөрөнгийн нийт хуримтлал	22.1	35.8	41.5	31.7	24.8
Үндсэн хөрөнгийн хуримтлал	23.3	26.1	29.3	26.8	17.9
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	-1.2	9.6	12.3	4.9	6.9
Цэвэр экспорт	2.5	-1.9	-6.1	8.6	1.8
Бараа, үйлчилгээний экспорт	57.0	57.0	63.8	76.3	75.2
Бараа, үйлчилгээний импорт	54.6	59.0	69.9	67.7	73.4
Статистикийн зөрүү (тэрбум төгрөгөөр)	-430	-1,147	-1,026	-1,573	-399

ХҮСНЭГТ 0.3. НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024Q1
	(тэрбум төгрөгөөр)				
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,444	14,306	18,522	24,310	7,673
Ирээдүйн өв сан	914	967	0	416	284
Тогтворжуулалтын сан	66	628	1,395	676	67
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,464	12,711	17,127	23,218	7,322
Татварын орлого	864	11,300	15,459	21,451	6,909
Орлогын албан татвар	2,227	3,326	3,827	5,800	2,557
Нийгмийн даатгалын орлого	1,586	2,286	3,038	3,943	920
Хөрөнгийн албан татвар	155	201	238	397	109
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,209	2,838	3,946	4,773	1,286
Онцгой албан татвар	777	827	848	790	280
Тусгай зориулалтын орлого	17	17	19	22	6
Гаалийн албан татвар	741	939	1,256	1,464	352
Бусад татвар, төлбөр, хураамж	800	866	2,288	4,262	1,398
Татварын бус орлого	952	1,412	1,668	1,767	413
Нийтлэг татварын бус орлого	785	1,250	1,364	1,430	339
Хөрөнгийн орлого	1	2	4	8	1
Тусламжийн орлого	166	160	300	330	73
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,904	15,630	18,160	22,454	5,695
Урсгал зарлага	10,829	12,804	14,229	17,047	4,698
Цалин, хөлс	2,649	2,532	1,666	2,322	1,081
Бараа, үйлчилгээний бусад зардал	2,202	2,170	2,140	2,740	687
Татаас	375	454	537	580	134
Урсгал шилжүүлэг	4,663	6,813	9,088	10,273	2,394
Зээлийн үйлчилгээний төлбөр	939	836	798	1,132	402
Гадаад	776	681	694	1,042	395
Дотоод	163	155	104	90	6
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	3,075	2,826	3,930	5,408	997
Хөрөнгийн зардал	3,034	2,982	3,803	5,175	843
Эргэж төлөгдөх цэвэр зээл	41	-156	127	233	154
НИЙТ ТЭНЦЭЛ	-3,460	-1,324	362	1,856	1,978
НИЙТ ҮНДСЭН ТЭНЦЭЛ	-2,521	-488	1,160	2,987	2,380
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-4,440	-2,919	-1,033	763	1,627
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ҮНДСЭН ТЭНЦЭЛ	-3,501	-2,083	-235	1,895	2,028

ХҮСНЭГТ 0.4. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024Q1
	(сая ам.доллараар)				
I. УРСГАЛ ДАНС	-675	-2,108	-2,304	121	-251
Бараа	1,756	1,370	1,233	4,549	920
Экспорт Ф.О.Б (кредит)	6,991	8,136	9,854	13,914	3,431
Импорт Ф.О.Б (дебит)	5,235	6,766	8,622	9,366	2,511
Үйлчилгээ	-1,450	-1,675	-2,355	-2,592	-846
Кредит	655	814	1,135	1,587	275
Дебит	2,105	2,490	3,490	4,179	1,121
Анхдагч орлого	-1,253	-2,232	-1,615	-2,233	-499
Кредит	341	292	344	455	132
Дебит	1,595	2,524	1,959	2,687	631
Хоёрдогч орлого	273	429	434	398	175
II. ХӨРӨНГИЙН ДАНС	103	114	154	135	32
Кредит	105	116	166	149	36
Дебит	2	2	12	14	4
III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэг+/зээллэг-)	-1,504	-1,982	-1,644	-1,477	-857
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-1,693	-2,060	-2,428	-2,172	-580
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	563	25	445	818	-16
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	-6	-8	-11	-2	8
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	-369	60	351	-121	-269
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	278	245	298	354	-245
Зээл	-803	-501	67	-529	-86
Худалдааны зээл	156	413	-15	54	61
IV. Алдаа болон орхигдуулга	-146	-209	-222	-276	-265
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	787	-222	-727	1,457	373
V. Нөөц хөрөнгө	787	-222	-727	1,457	373
ГВУН	787	-225	-751	1,398	359
ОУВС-гийн зээл	0	-3	-24	-59	-14
Тусгай санхүүжилт	0	0	0	0	0
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Нэрлэсэн ДНБ (сая ам.доллараар)	13,314	15,286	17,150	19,872	4,850
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	4,534	4,366	3,400	4,921	5,250
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	7.4	5.7	3.4	4.4	17.3
Валютын ханш MNT/USD (дунджаар)	2,813	2,849	3,140	3,466	3,392
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	2,850	2,849	3,445	3,411	3,376

ХҮСНЭГТ 0.5. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
	2020	2021	2022	2023	2024Q1
(тэрбум төгрөгөөр)					
Гадаад цэвэр актив	5,816	3,806	2,492	8,959	9,775
Дотоод цэвэр актив	18,664	24,057	27,173	28,665	27,625
Дотоодын цэвэр зээл	19,136	24,298	25,648	29,106	28,477
Бусад цэвэр зүйлс	-472	-241	1,525	-441	-852
M2 мөнгө	24,481	27,863	29,665	37,624	37,400
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	753	847	831	906	827
Харилцах болон хадгаламж	23,728	27,016	28,834	36,719	36,573
(өсөлт, хувиар)					
Жилийн өсөлт					
M2 мөнгө	16.2	13.8	6.5	26.8	20.9
Гадаад цэвэр актив	80.9	-34.6	-34.5	259.6	148.4
Дотоод цэвэр активын өсөлт	4.6	28.9	13.0	5.5	2.3
Дотоодын цэвэр зээл	2.3	27.0	5.6	13.5	12.4
ЗГ-аас авах авлага	-29.6	-49.8	107.6	91.3	57.9
Бусад салбараас авах авлага	-2.2	19.2	9.9	19.8	18.5
Улсын байгууллагаас авах авлага	1,492.6	25.0	-5.0	-16.7	-8.6
Хувийн сектороос авах авлага	-7.2	18.8	10.8	21.7	19.8
(нэгж хувиар)					
M2 мөнгөний өсөлт дэх оролцоо					
M2 мөнгө	16.2	13.8	6.5	26.8	20.9
Гадаад цэвэр актив	12.4	-8.2	-4.7	21.8	18.9
Дотоод цэвэр актив	3.9	22.0	11.2	5.0	2.0
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Мөнгөний эргэлтийн хурд	1.5	1.6	1.8	1.8	1.9
Нэрлэсэн ДНБ-ий өсөлт (хувиар)	-1.0	16.3	23.6	27.9	19.4
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	2.3	13.8	13.2	7.9	7.0

Ашигласан материалын жагсаалт

Argia, Sbordone. 2002. "Prices and Unit Labor Costs: A New Test of Price Stickiness." *Monetary Economics* 265-292.

Gali Jordi, Mark Gertler. 1999. "Inflation Dynamics: A Structural Econometric Approach." *Monetary Economics* 195-222.

Muto, Ichiro. 2007. "Estimating a New Keynesian Phillips Curve with a Corrected Measure of Real Marginal Cost: Evidence in Japan." *Monetary and Economic Studies* 6-9.

Wolman, Alexander. 1999. "Sticky Prices, Marginal Cost, and the Behavior of Inflation." *Federal Reserve Bank of Richmond, Economic Quarterly* 29-48.

ХОЛБОО БАРИХ:

Утас: +976-51-263333

Факс: +976-51-263333

И-мэйл: info@med.gov.mn

Вэбсайт: med.gov.mn

Фэйсбүүк: [medgovMN](https://www.facebook.com/medgovMN)

ХАЯГ:

Эдийн засаг, хөгжлийн яам

Монгол Улс, Улаанбаатар хот,

Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж

Засгийн газрын XI байр